

05 дугаар сарын үйл ажиллагааны мэдээ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар

МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй, ил тод, нээлттэй үзүүлэх" үндсэн зорилтын хүрээнд зохион байгуулагдсан төрийн үйлчилгээний нэгдсэн систем, WWW.E-MONGOLIA.MN дотоод удирдлагын системийн сургалтад аймаг, сумдын ЗДТГ-ын мэргэжилтнүүд хамрагдаж мэдээлэл авлаа. Энэ үеэр төрийн үйлчилгээг цахимжуулах, онлайн хэлбэрт шилжүүлэх ажилд шаардагдах 195.0 сая төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг 13 сумын Засаг даргын Тамгын газарт гардууллаа.

Төрийн албаны салбар зөвлөл: Төрийн албаны тусгай шалгалтыг энэ сард 4 удаа зохион байгууллаа. Нийт 35 ажлын байр зарлагдсанаас Мөнххаан, Асгат, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Сүхбаатар, Наран, Дарьганга сумын Санхүүгийн албаны дарга Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, Санхүүгийн хяналт аудитын албаны Санхүүгийн хяналт, шалгалтын улсын байцаагч, Дотоод аудитор, Мэргэжлийн хяналтын албаны Хэлтсийн дарга болон Холбоо мэдээлэл харилцааны хяналтын улсын байцаагчийн ажлын байрууд тус тус нөхөгдсөн байна.

Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад удирдах албан тушаалын 28 албан хаагч, Төрийн албаны мэргэшүүлэх богино хугацааны сургалтад 8 албан хаагч, төрийн албанд шинээр ажилд орсон иргэдийг мэргэшүүлэх багц сургалтад 6 албан хаагч тус тус хамрагдаж сертификат авлаа.

Төрийн албан зөвлөлд аймгийн хэмжээний 21 байгууллагын 83 албан хаагчийг хамруулсан төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн гишүүдийн судалгааг хүргүүлээ.

Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр: Сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлаг, төсөвт байгууллагуудыг 2019 оны үйл ажиллагааны хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр нь байр эзлүүлж дүгнэлээ. 1-р байранд Мөнххаан сум, 2-р байранд Халзан сум 3-р байранд Наран сум тус тус шалгарч шагналаа гардан авлаа.

Хоёр. Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд:

2020 оны 5 дүгээр сард улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр болон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогоор нийт 19,250.8 сая төгрөг авч, орон нутгийн төсөвт 2,967,3 сая төгрөгийн орлого орж нийт 22,218,1 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллалаа.

Эхний 5 сарын байдлаар Улсын төсөвт 1230,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 1115,8 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 90,7 хувиар, Орон нутгийн төсөвт 3544,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 3977,7 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 112,2 хувиар тус тус биелүүлсэн байна.

Аймгийн төсвөөс сумдад 2458,7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн 13 байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн 56 байгууллагад нийт 18,726.8 төгрөгийн санхүүжилтыг тус тус олгосон байна.

ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 2448,3 сая төгрөг. Үүнээс 2036,1 сая төгрөг нь Төсвийн тухай хуулийн 60.2.6, 60.2.7 дэх эх үүсвэр болох ашиглалт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл болон мега төслийн АМНАТ төлбөр бөгөөд холбогдох журмын дагуу сумдад 1283,5 сая төгрөгийг хуваарилсан.

Төсвийн татварын орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх зорилгоор хөрөнгийн татвар хураалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд аймгийн Татварын хэлтэс, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Автотээврийн төвтэй хамтран ажиллаж байна.

Аймгийн төсвийн татварын бус орлогыг эрчимжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 179 дүгээр тогтоолын дагуу уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг ААН-тэй байгуулсан хамтран ажиллах гэрээний 2019 оны хэрэгжилт, 2020 оны гэрээ байгуулах үйл ажиллагааг зохион байгуулах / Covid-19 цар тахлын хүрээнд Тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн олборлолт,

тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогссон, хилийн боомт хаалттай / талаар аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХТ-дэд танилцуулж ажиллалаа.

2019 оны аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд Төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.

Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх цахим сургалтад 5 албан хаагч хамрагдаж, уг системийг аймагт нэвтрүүлэх сургагч багшаар бэлтгэгдсэн.

Татварын хэлтэс: Аймгийн Татварын хэлтсээс Хуулийн этгээдийн бүртгэлийн хэлтэстэй хамтарсан хуулийн этгээдийн бүртгэлийг татвар төлөгчийн бүртгэлтэй тулгаж, зөрүүг арилгах ажлыг зохион байгуулж байна

ХХОАТ-ын тухай хуулийн заалтын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр хүсэлтээ ирүүлсэн 896 иргэдийн 464,8 сая төгрөгийг олгосон байна.

Орон нутгийн өмчийн газар:

Худалдан авах ажиллагааны хүрээнд: 2020 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 94 нэр төрлийн 23,699,2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгдсөн байна. Үүнд: 5-р сард нийт 5297,8 сая төгрөгийн 16 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг цахимаар зарласан байна. Мөн тухайн сард 17 нэр төрлийн тендерийн нээлт хийж, 2318,6 сая төгрөгийн 10 нэр төрлийн тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж захиалагчид холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн байна. 850,0 сая төгрөгийн өртөг бүхий 2 нэр төрлийн тендер шалгаруулалт үнэлгээ хийгдэж байна.

Нийт 6 нэр төрлийн төсөл арга хэмжээ гүйцэтгэгч сонгон шалгараагүй тул дахин зарласан байна.

Өмчийн бүртгэл, хяналтын хүрээнд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10/11 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчт эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу орон нутгийн өмчт 5 байгууллагаас ирсэн санал хүсэлтийг тухай бүр хариуг шийдвэрлэж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд хүргүүлж ажилласан.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар тогтоолын дагуу дуудлага худалдааг 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулсан боловч оролцогч ирээгүй болно.

Санхүүгийн хяналт, аудитын алба: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Боловсрол-Өргөө” дотуур байр, Онгон, Дарьганга сумдын төсөвт газруудын 2018, 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд нь төлөвлөгөөт санхүүгийн хяналт шалгалт, ЗДТГ, ИТХурлын үйл ажиллагаанд дотоод аудит, мөн дээрх сумдын “Дарьганга-тохижилт үйлчилгээ”ОНӨААТҮГазар, “Онгон-Арвижих” ОНӨААТҮГазар, “Сүхбаатар-Ойжуулалт сум дундын ойн анги”ОНӨААТҮГазарт дотоод аудит хийж 6 салбар актаар 25833.2 мянган төгрөгийн төлбөр тогтоож, хугацаатай албан шаардлага, зөвлөмжүүдийг хүргүүлж ажиллалаа.

Статистикийн хэлтэс: “COVID-19 вирусээс шалтгаалан үүссэн нөхцөл байдал болон зохицуулж буй арга хэмжээ нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хэрхэн нөлөөлж буйг судлах” судалгааг 2020 оны 05 дугаар сарын 01-нээс 19-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд иргэд, аж ахуй нэгж байгууллагууд бүрэн хамруулах ажлыг сумдад хэлтсийн даргын албан тоот хүргүүлж нийтийн сошиал сүлжээ болон утсаар холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Хөдөө аж ахуйн түүвэр судалгааны /Малын ашиг шим болон газар тариалангийн судалгаа/ 1 дүгээр улирлын мэдээллийг сонгогдсон 8 сумын 8 багийн 160 өрхөөр бөглүүлэн татан авч, хянаж шалгах ажил хийж, програмд оруулан Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлээд байна.

Хагас жилийн малын түүвэр судалгааг 05 дугаар сарын 25-наас 31-ний хооронд 13 сумын 67 багийн түүвэрлэгдэн ирсэн 1642 өрх, ААНБ-ыг цуглуулах ажил хийгдэж байна. Энэхүү ажлын хүрээнд сумдын Засаг дарга нарт хагас жилийн малын түүвэр судалгааг чанартай зохион байгуулж явуулах, бэлтгэл ажлыг хангах талаар чиглэл өгч ажилласан бөгөөд аймгийн Засаг даргын 2020 оны А/344 дүгээр захирамжаар сумдын тооллогын комисс, түүний ажиллах зарчмын хүрээнд зөвлөмж, үүрэг, даалгаврыг өгсөн. Мөн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Түмэнцогт, Мөнххаан, Уулбаян, Дарьганга, Наран, Онгон сумдад хяналтын 2 групп ажиллаж байна.

Гурав. Хууль эрх зүйн салбарт:

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийг хамгаалах газарт 2016-2019 оны тайланг гаргаж хүргүүлээ.

Үндэсний аюулгүй байдлын чиглэлээр аймгийн Засаг даргын Тамгын газраас 2020 онд зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Архивын чиглэлээр: Лавлагаа 78, хуулбар 27 нийт 51 иргэдэд хөдөлмөрчдөд давхардсан тоогоор 341 гаруй хадгаламжийн нэгжээр үйлчилсэн.

Цахимд хадгаламжийн нэгж буюу 1220 хуудас баримтыг скайнер, photoshop-д оруулаад байна. Нөхөн бүрдүүлэлтээр Барилгын зураг төслийн 25 хадгаламжийн нэгж хүлээн авсан.

Улсын бүртгэлийн хэлтэс: Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-177, анхны бүртгэл-24, өмчлөх эрх шилжих гэрээ-21, барьцааны гэрээ-110, бүртгэлд өөрчлөлт оруулах -1, лавлагаа хуулбар-17, нийт бичигдсэн гэрчилгээний тоо-17,

Газар өмчлөх, эзэмших ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээ: Хүлээн авсан мэдүүлгийн тоо-124, анхны бүртгэл-15, өмчлөх эрх шилжих гэрээ-20, барьцааны гэрээ-88, бүртгэлд өөрчлөлт оруулах -6, лавлагаа хуулбар-2 нийт бичигдсэн гэрчилгээний тоо-38, нийт бичигдсэн лавлагааны тоо-2

Хуулийн этгээдийн бүртгэл: 2020 оны 05 дугаар сарын байдлаар улсын бүртгэлд бүртгэлтэй нийт хуулийн этгээдийн тоо 1193. Тухайн сард шинээр нийт ХК-2, ХХК-619, төрийн бус байгууллага-118, төрийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -1, орон нутгийн өмчит аж ахуй тооцоотой үйлдвэрийн газар -22, улсын төсөвт үйлдвэрийн газар-137, нөхөрлөл-75, хоршоо-80, хадгаламж зэлийн хоршоо-4, сан-3, үйлдвэрчний эвлэлийн байгууллага-42, шашны байгууллага-11, хэвлэл мэдээллийн байгууллага-2, татан буугдсан улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээд-59, үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон улсын бүртгэлийн гэрчилгээг дахин бүртгэсэн-196, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгэсэн-413, хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт хийсэн-443, хуулийн этгээдэд тамга, тэмдгийн хяналтын хуудас олгосон-406, хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг-167, лавлагаа-4, нэрийн баталгаажуулалт-12

Иргэний бүртгэл: Иргэний бүртгэлийн тасаг нь 2020 оны 05 дугаар сарын байдлаар нийт 110 төрөлт, гэрлэлт 36, гэрлэлт цуцлалт 4, үрчлэлт 3, эцэг тогтоолт 4, овог нэр өөрчлөлт 4, нас баралт 33, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 0, үндэсний энгийн гадаад паспорт 15, шинээр олгосон иргэний цахим үнэмлэх 84, иргэн, аж ахуй нэгжид олгосон лавлагаа 622 тус тус бүртгэгдэж олгосон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2020 оныг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах жил” болгосонтой уялдуулан Сүхбаатар аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2020 оныг “Алба хаагчийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлж, нийгмийн баталгааг сайжруулан хамтач ажиллагааг хэвшүүлэх жил” болгон зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилтын хүрээнд алба хаагчдын нийгмийн асуудлыг ажлын хүрээнд албаны 8 айлын орон сууцны гадна тохижилт, нарийн ногоо тариалах хүлэмжийн асуудлыг шийдвэрлэж тариалалтыг эхлүүлсэн.

Мөн олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан тус газраас хүүхдийн тэтгэлэг авагч хүүхдүүдийн дунд “Аавдаа захидал бичээрэй” нэг сарын аяныг зохион байгуулсан.

Тус газрын хорихоос өөр төрлийн ялын хяналтад 2020 оны 05 дугаар сарын байдлаар торгох ялаар шийтгүүлсэн урьд оны үлдэгдэл 11 ялтны 42470,0 төгрөгийн материал дээр шүүхийн шинээр 81 ялтны 75500.0 төгрөгийн шийтгэх тогтоол хүлээн авч, 72 ялтны 48400.0 төгрөгийн ялын биелэлтийг хангаж, 20 ялтны 69570.0 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нийтэд тустай ажил хийлгэх урьд оны үлдэгдэл 7 ялтны материал дээр шүүхээс шинээр 16 ялтны 6160 цагийн ялын материалыг хүлээн авч, 7 ялтны 3676 цагийг хорих ялаар солиулж, 1 ялтны 320 цагийг шүүхээс хүчингүй болгосон бөгөөд 10 ялтны 520 цагийн ялын хугацаа дуусаж, үлдэгдэл 5 ялтны ял эдлэлтэд хугацаа тавин ажиллаж байна. Эрх хасах ялын урьд оны 24 ялтны 15758 хоногийн үлдэгдэл дээр 4 ялтны 3285 хоногийн материал нэмэгдэж, 1 ялтны үлдэгдэл 72 хоногийн хугацаа дуусаж одоо 26 ялтны ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Хөрөнгө орлого

оруулалтаар баригдаж буй сургууль, дотуур байр, цэцэрлэг, Соёлын төвийн барилгын үйл ажиллагаатай танилцан мэдээллийг нэгтгэн БСШУСЯ-нд хүргүүлээ.

Тахилга шүтлэгт газар нутгийн улсын бүртгэл мэдээллийн сан үүсгэх ажил хийгдэж эхлээд байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, 2018 оны 46 дугаар зарлиг, Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Үндэсний бичиг, соёлын баярыг угтан “Сайхан бичигтэн байгууллага, хамт олон, иргэн” шалгаруулах уралдааныг Насан туршийн боловсролын төв, Нийтийн номын сантай хамран 05 сарын 05-08-ны өдөр хүртэл “Хүмүүн бичиг- Хүн бүрийн бичиг” олон нийтийн сүлжээг ашиглан цахим хэлбэрээр зохион байгууллаа. Сайхан бичигтэн байгууллага шалгаруулах уралдаанд 29 байгууллагын 591 төрийн албан хаагч оролцож:

- Тэргүүн байранд Ерөнхий боловсролын 1-р сургууль
- Дэд байранд Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар
- Гутгаар байранд 4-р цэцэрлэг

Сайхан бичигтэн иргэн шалгаруулах уралдаанд:

- ✓ Тэргүүн байр Ө.Гансүвд
- ✓ Дэд байр Б.Мөнхзул
- ✓ Гутгаар байр З.Эрдэнэбаатар нар тус тус шалгарав.

Үндэсний бичиг үсгийн талаарх мэдлэг, мэдээллийг бататгах зорилгоор БСУГ-аас ЕБ-ын 3-р сургуулийн Монгол хэлний багш Д.Дулмаатай хамтран Монгол бичгээр унших, зөв бичих чадвар шалгах цахим сорил бэлтгэн уралдаан зохион байгууллаа. Тус уралдаанд мэргэжлийн бус сонирхогч 42 иргэн оролцож хариултаа илгээсэн байна.

Сүхбаатар аймгийн Нээлттэй даалгаврын сан бүрдүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 17 судлагдахуунаар шинэ хичээлийн жилийн эхний нэгж хичээлээр даалгавар боловсруулах ажлыг БСУГ-ын мэргэжилтнүүдийн удирдлага дор сургууль бүр хуваарийн дагуу хийж гүйцэтгэж байна.

Боловсрол, соёл урлагийн газраас сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудын дунд “ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАН БАЙГУУЛЛАГА ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ” сэдэвт шилдэг илтгэлийн уралдаан зарлаж дүнгээ гаргалаа. 1-р шатанд ЕБС-ийн захирал 8, СӨБ-ын эрхлэгч - 17 нийт 25 удирдах ажилтан бүтээлээ ирүүлсэнээс Халзан, Түмэнцогт сумдын сургууль, 2, 3-р сургуулийн захирал, Мөнххаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч нарын 5 илтгэл 2-р шатны шалгаруулалтад уншигдлаа.

Аймгийн хэмжээнд теле хичээл үзэлт 73,1%-тай байгаагаас Бага ангид 75%, Дунд ангид 71,4%, Ахлах ангид 72,9% хувьтай байна.

ЭЕШ-ын бэлтгэлийн ирц **96-98,4%** хүртэл ахисан байна. 12-р ангийн сурагчдын дунд ЭЕШ- бэлтгэх зорилгоор нийт **107** удаагийн сорил, шалгалт авсан мэдээ ирүүлээд байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулсан онлайн сургалтад БСУГ-ын мэргэжилтнүүд 100 хувь хамрагдаж батламжаа хүлээн авлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Оёдол, эсгүүрийн 2 дахь ээлжийн сургалтад 6 хүн хамруулж, Заавал сурах 16 бүжгийн цуврал теле хичээлийг бэлтгэн орон нутгийн телевиз болон цахим орчинд байршуулж, Сэтгэлзүйн цуврал подкастын 2 дугаарыг бэлэн болгож олон нийтэд хүргэсэн.

"Залуучууд коронавирсийн эсрэг нэгдэж байна" аяны хүрээнд 2 дахь удаагаа орон нутгийн иргэдэд 400 ширхэг амны хаалтыг үнэгүй тараасан. Мөн амны хаалтыг тогтмол зүүхийг зөвлөж, иргэдэд уриалж ажилласан.

Лантуун Дохио ТББ-ын сайн дурын залуучуудын төлөөлөл Сүхбаатар аймгийнхаа залуучуудыг дэмжин Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, залуучуудын хөгжлийн төв, түүний дэргэдэх сайн дурын залуучуудын клуб “Лантуухүүгийн богц-Сүхбаатар аймагт” аяныг хамтран зохион байгуулсан.

“Ирээдүйн эзэд” мэргэжил сонголтын аяны хүрээнд Гэр бүлийн радиотой хамтран подкаст хийсэн. Үүнд мэргэжил сонголтыг таниулах, Мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө, нийгэмд ямар мэргэжил эрэлт хэрэгцээтэй байна вэ, хүүхдүүд зорилгодоо хүрэхийн тулд мэргэжлээ хэрхэн сонгох талаар хаанаас зөвлөгөө зөвлөмжийг авах гэх зэрэг сэдвээр ярилцаж олон нийтэд хүргэсэн. Мөн мэргэжлээ хэрхэн сонгох талаар зөвлөгөө бүхий постерийг бэлтгэн орон нутгийн facebook группүүдэд түгээсэн.

Гамшиг онцгой байдлын үед хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгааллын талаар хууль тогтоомж төрийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор төрийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх хамтарсан багт мэдээлэл арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг 8 суманд зохион байгуулсан.

Гэр бүлийн зөрчил үйлдэж аймгийн Цагдаагийн газарт баривчлагдсан иргэдэд “Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт”-ын хөтөлбөрийн дагуу холбогдох арга хэмжээг авч, 22 иргэнийг сургалтад, 7 иргэнийг нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд тус тус хамруулсан.

“ШУ-ны үндэслэлтэй угийн бичиг хөтлөх арга зүй” сэдэвт 10 цуврал теле хичээлийг бэлтгэн орон нутгийн телевиз, олон нийтийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэж, Зорилтот бүлгийн өрхийн хүүхдүүдийг витаминжуулалтад хамруулаа.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан үндэснийхээ дээд хувцас, өв соёл, ёс заншилыг өсвөр үе залуучуудад сурталчлах түгээн дэлгэрүүлэх үндэсний хувцсаараа бахархах, эдэлж хэрэглэж сурах, монгол хүний үнэт зүйлсийг олонд таниулах зорилгоор “ТАЛ НУТГИЙН ГОЁЛ” үндэсний хувцсаар гоёсон гэр бүлийн фото зургийн уралдааныг зохион байгууллаа. Уг уралдаанд 30 гэр бүл оролцсон байна.

Охидын дуу хоолойг сонсож тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тэдгээрийг хөгжүүлэх зорилгоор 5-9 дүгээр ангийн охидыг хамруулсан “Нандин” групп нээж ажиллаж байгаа бөгөөд одоогоор Зорилго-зорилгыг бодит болгох, өөртөө итгэх итгэл, айдсыг даван туулах, тэдний насны онцлогт тохирсон хувь хүний хөгжилд зориулсан болон сэтгэл зүйн мэдээ мэдээллийг хүргэж байна мөн өдөр бүрийн 15-16 цагийг охид зөвхөн өөрөө өөрийгөө өөрчлөлтийн цаг болгон ажиллаж байна. Одоогоор группт 255 гаруй гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

“Хамгаалагдсан хүүхэд- Хариуцлагатай эцэг эх” аяны хүрээнд осол гэмтлээс сэргийлж 0-10 насны хүүхдийг замын хөдөлгөөнд оролцохдоо зориулалтын суудлын бүстэй байх зөвлөгөө зөвлөмжийг өгөн, хяналт шалгалт хийх ажлыг Цагдаагийн газартай хамтран зохион байгууллаа.

Ковид-19 цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор **“Хайрын сар”** аяны хүрээнд шүлгийн цахим уралдааныг зарлав. Уг тэмцээний зорилго нь нэрт яруу найрагч О.Дашбалбарын “Амьддаа бие биеэ хайрла” шүлгийн үзэл санаагаар дамжуулан ирээдүй хойч үе, хүүхэд, залуучууд, өсвөр үеийнхэнд хүн хүнээ хүндэлж, хайрлах, халамжлах, өөрийгөө хайрлаж хамгаалж амьдрах, амьдралын үнэ цэнийг мэдрүүлэх үзлийг түгээн дэлгэрүүлэх явдал бөгөөд одоогийн байдлаар шүлгийн уралдаанд 20 хүүхэд бичлэгээ ирүүлээд байна.

Соёл урлагийн чиглэлээр:

Хөгжимт жүжгийн театр: Жаахан шарга” театр нь шилдэг уран бүтээлийн түүвэр LIVE тоглолтоо 05-р сарын 29-нд BBS TV болон BBS телевиз цахим хуудсаар шууд дамжуулан хүргэсэн. Нийт 3 цуврал тоглолт хийхээр төлөвлөсөн байгаа бөгөөд энэ удаагийн тоглолтонд 40 гаруй уран бүтээлч нутгийн онцлогийг агуулсан хөгжмийн 2, бүжгийн 2, гоцлол дуу 2, чуулбар 1, нийт 7 номер бүхий тоглолтоо олон нийтэд толилуулсан байна.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2017 оны 2-р сарын 23-ны А/69 дүгээр захирамж, холбогдох журмын дагуу 2019 онд Олон улсын хэмжээ мастер, Спортын мастер, Спортын дэд мастерын болзол хангасан болон өсвөр үе, насанд хүрэгчдийн Улсын аварга, Дэлхийн аварга Азийн аварга, Олон улсын хэмжээний тэмцээнд спортын өндөр амжилт гаргасан баг тамирчид, дасгалжуулагч нарт аймгийн Засаг даргын захирамжийн дагуу мөнгөн шагнал гардууллаа. Мөнгөн шагналд 150 багш дасгалжуулагч, тамирчид хамрагдсан ба 24.2 сая төгрөгийг олголоо.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/288 дугаар захирамжийн дагуу Усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн үйл ажиллагааг Аймгийн Онцгой комисс, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газрын өгсөн заавар зөвлөмжийн дагуу бэлтгэл ажлыг ханган энэ сарын 13-ны өдрөөс эхлэн нээж, тусгай горимоор ажиллуулж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор BBS телевизтэй хамтран спортын төрлүүд болон гэрийн нөхцөлд идэвхтэй хөдөлгөөн, бие бялдарын чадвар, чадамжийг дээшлүүлэх зорилгоор цуврал болгон TV хичээл бэлтгэн явуулж байна.

Эрүүл мэндийн чиглэлээр: Улсын хэмжээнд зохион байгуулагдсан гамшгаас хамгаалах арга хэмжээний цахим дадлага сургуулилтад хариу арга хэмжээний 4 багийн төлөөлөл 25 мэргэжилтэн цагийн байдал дээр ажиллаж дадлага сургуулилт хийлээ.

2019 онд байгууллагынхаа ажилтан албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах талаар идэвхи чармайлт гарган ажиллаж “ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА”-аар шалгарсан байгууллагуудад шагналыг олгов.

Бичигт боомтоор газрын тос тээвэрлэхтэй холбоотойгоор бэлэн байдлыг хангахаар аймгийн онцгой комиссоос томилогдсон ажлын хэсэгт эрүүл мэндийн салбараас төлөөлөл оролцож 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж, заавар зөвлөмж өглөө.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаатай холбогдуулан хариуцлагатай жижүүр ажиллуулж, эрүүл мэндийн салбарын мэдээ, мэдээллийг хүлээн авч ЭМЯ-д 25 удаа, Аймгийн шуурхай штаб, Мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын хэлтэст 50 удаа дамжуулсан байна.

Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ариутгал халдваргүйтгэл, эм эмнэлгийн хэрэгсэл, дайчлан ажиллах хүн хүчний төлөвлөгөөг тодотгож, 200 ортой хээрийн эмнэлгийн төлөвлөлтийг хийн ажиллаж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уулбаян сумын ЭМТ-д магадлан итгэмжлэлийн шалгалтын баг ажиллаж заавар зөвлөгөө өгч хяналт хийж ажилласан

Эрүүл мэндийн салбарын эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах цахим сургалтыг 4 удаа зохион байгуулж 340 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамрууллаа.

Маскаа зүүцгээе аяны хүрээнд олон нийтийн газар бөөгнөрөл үүсэх, бага насны хүүхдийн осол, гэмтэл, ахуйн хүрээний архидалтаас урьдчилан сэргийлэх, хорио цээрийн дэглэмийн үед иргэдэд халдвараас хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл, зөвлөмж өгч, материал тараасны зэрэгцээ халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж давхардсан тоогоор 37 спорт заал, 7 тоглоомын газар, 35 тоглоомын талбай, 50 үйлчилгээний газруудаар явж зөвлөмж өгч ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн талаар: 2020 оны 05-р сарын 25- ны байдлаар хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй ажил хайгч 633 иргэнээс эмэгтэй 292 бүртгэлтэй ажилгүй иргэн 468 иргэнээс, эмэгтэй 216 иргэн байна. 359 ажлын байрны захиалга бүртгэгдэж, 227 иргэнийг ажилд зуучилсан байна. Ажилд зуучлагдсан иргэдийн 113 иргэн буюу 58.5 % нь байнгын ажлын байртай болсон байна. Шинээр бий болсон 118 ажлын байрны мэдээллийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

Төсөл хөтөлбөрүүдийн дагуу бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээг 9 суманд хэрэгжүүлэхээр шийдвэрлэж шаардлагатай тоног төхөөрөмж, үрийг хүлээлгэн өгөв. Баруун-Урт сумын хоёр бүлгийн үйл ажиллагааг эхлүүлж газрыг хагалуулж борнойдуулан усалгааны системийг засаж төмс, нарийн ногоо хүлэмжинд огурци помидор суулгаад байна.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 40 иргэнийг хамруулж 195,0 сая төгрөг, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэгт 9 сумын 12 ахмадын төслийг дэмжин 24,0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн санхүүгийн дэмжлэгт 12 сумын 14 төслийг дэмжин 55,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр болж гэрээ байгуулан санхүүжилтийг олгоод байна. Нийтийг хамарсан ажилд 12 сумын 17 төслийг сонгон шалгаруулж 237 иргэнийг түр ажлын байраар хангахаар шийдвэрлэлээ.

Баруун-Урт суманд 2019 онд олгосон “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот” төслийн санхүүжилт авсан иргэдийн үйл ажиллагаанд байгууллагын хяналын шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулав.

Нийгмийн халамжийн талаар: 2020 оны 05-р сард 13 сумын 23 иргэний нийгмийн халамжийн тэтгэмж, 4 иргэний халамжийн тэтгэвэр, 17 иргэний ахмадын хөнгөлөлт, 3 иргэний хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 41 иргэний цалинтай эхийн тэтгэмж, 46 иргэний жирэмсэн эхийн зэрэг нийт 134 хувийн хэргийг хүлээн авч хянан нийгмийн халамжийн үйлчилгээний мэдээллийн системд баталгаажуулсан. Сумдын мэргэжилтнүүдээс тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт тусламж авах 97 иргэдийн жагсаалтыг авч WAIS программд баталгаажуулалтыг хийсэн.

2020 оны 05 дугаар сард олгох 2397 иргэний 570057,3 мянган төгрөгийн тэтгэвэр , 1429 иргэний 191047,7 мянган төгрөгийн тэтгэмж , 61 иргэний 13706,3 мянган төгрөгийн ахмадын хөнгөлөлт, 195 иргэний 6752,4 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, 700 иргэний 24014,3 мянган төгрөгийн жирэмсэн эхийн тэтгэмж, 17 иргэний 2343,5 мянган төгрөгийн алдар цолтой ахмадын хөнгөлөлт, 3395 иргэний 165951,1 мянган төгрөгийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийг арилжааны банкаар дамжуулан иргэдэд олгож байна.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан 1334 өрхөд зөвшөөрөгдсөн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх хүнсний дэлгүүр сонгон шалгаруулах тендерийг Орон нутгийн өмчийн газраар зарлуулж сонгон шалгаруултыг хийснээр 13 сумын 18 байгууллагатай 2020 оны 12 дугаар сарын 31-г дуустал хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Баруун-Урт сумын 659 өрхөд зөвшөөрөгдсөн 10 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлэх байгууллагаар Баруун-Урт сумын “Баялагийн-Ундрах Баруун-Урт” ХХК, “Өсөхдэлгэр ундрах” ХХК, “Батгарьд Эрдэсбаяр” БГБХН, “Чандмань дэлгэр ундрах” ХХК, “ИТМТ” ХХК-д шалгарсан байна.

Шинэ төрлийн корона вирустэй холбоотой өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаа хийгдэхгүй байгаатай холбоотой судалгаанд хамрагдаагүй 45 өрхийн өргөдлийн дагуу 110 хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбарыг авч өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн программын хүүхдийн мөнгө цэсэнд бүртгэв.

2020 оны 05 дугаар сарын байдлаар өрхийн мэдээллийн нэгдсэн санд 19699 хүүхэд бүртгэгдэж, хүүхдийн мөнгөнд хамрагдаж байгаа нь аймгийн 23300 хүүхдийн 85 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 05 сард 2 удаа хуралдаж 22 хүүхэд орж 20 - хүүхэд асаргаа сунгагдаж, 4 - хүүхэд асаргаа шинээр тогтоосон байна.

Тав. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрээнд:

Барилга, хот байгуулалт, газрын харилцаа: Баруун-Урт, Мөнххаан сумдад 3 байршилд газар эзэмших эрхийн дуудлага худалдаа зохион байгуулж төсөвт 23,5 сая төгрөг төвлөрүүлсэн. Мөн Баруун-Урт суманд 2020 оны 5 дугаар сарын 25, 27-ны өдрүүдэд 2 байршилд, Мөнххаан сумын Бүрэнцогтод 5 байршилд тус тус газар эзэмших эрхийн нээлттэй дуудлага худалдаа танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулагдсан.

Бүх суманд хаягжуулалтын мэдээллийг кадастрын мэдээллийн сан, хаягийн мэдээллийн сантай тулгах, шалган баталгаажуулах ажлыг хийсэн.

Баруун-Урт сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдсан Дунд ангиллын 25 айлын хүчин чадал бүхий “Даймонд” хотхоны 2 дугаар ээлжийн орон сууцны барилга зориулалттай барилга байгууламжид аймгийн Засаг даргын 2020 оны А/238 дугаар захирамжаар баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах 17 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс улсын комиссыг хуралдууллаа.

Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдсан Ерөнхий боловсролын лаборатори 1-р сургуулийн урлаг заалны дээврийн засварын ажилд 6 хүний бүрэлдэхүүнтэй улсын комиссыг хуралдууллаа.

Аймгийн засаг даргын тамгын газрын захиалгаар хэрэгжсэн “АНЭ-ийн ариутгалын тасгийн цахилгааны засвар”-ын ажилд 8 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс, БСШУСЯамны захиалгаар хэрэгжсэн Асгат сумын Соёлын төвийн их засварын ажилд 12 хүний бүрэлдэхүүнтэй улсын комисс ажиллан үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэлээ.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ Мөнххаан сумдад ажиллаж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Спорт заал, 240 хүний суудалтай соёлын төв, 75 ортой дотуур байр, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлуудтай танилцаж, тохирлын гэрчилгээтэй материал хэрэглүүлэх, Орон нутгаас ашиглаж буй түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах гэрээг сумын ЗДТГ-тай байгуулан төлбөрийг төвлөрүүлэх, сумдад ашиглаж буй түүхий эдийг шинжилгээнд хамруулан стандартын шаардлага хангаж буйг тодорхойлох ажлын хүрээнд

сумаас элсийг хайрга дайргыг очиж аван лабораторит шинжлэхээр дээжийг авчирч ажиллах, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж зөвлөмж үүрэг даалгавар өгч ажиллалаа.

Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид хайрга 5, элс 3, үл эвдэх 5 цэг дээжийг хүлээн авч нийт 9 дээжид сорилт шинжилгээ хийж үр дүнг боловсруулан хариуг олголоо.

Барилгад хэрэглэх гол нэрийн барилгын материалын үнийн төрөлжсөн судалгааг орон нутгийн хэмжээнд хийж, Барилгын хөгжлийн төв kh.ainur@barilga.gov.mn хаягаар хүргүүлэн ажиллаа.

Барилгын материал үйлдвэрлэгч аж ахуй нэгж Бага-Өлгий ХХК, Сэвүүн уудам тал ХХК-ны үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж чиглэл өгч ажиллалаа.

Хөдөө аж ахуйн салбарт: Зах зээл ба бэлчээр удирдлагын хөгжил төслөөс хэрэгжүүлж буй ажлын хүрээнд хийгдэх

1. Бог малын угаалгын ванн шинээр барих багц-1, багц-2 дээр Том ноёд ХХК
2. Өвс тэжээлийн агуулах саравч засварлах /Дарьганга сум/ -Алтан Орд констракшн
3. Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих /Уулбаян сум/ -Молцог элс ХХК-тай тус тус гэрээ байгуулан ажиллаж байна.

Мал аж ахуйн чиглэлээр: Үржлийн малд үзлэг ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд 7 сумын 15540 толгой малд / 9940 бод, 5600 бог/ үзлэг ангилалт хийх ажлыг хийж гүйцэтгүүлэхээр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Баясгалант сүрэг”, “Үзэмчин хонь”, “Удмын сангийн үндэсний төв”, “Түмэнцогт ОНӨҮГ” , “Дэлгэрэн дэврэх буян” ХХК зэрэг үржлийн аж ахуй нэгжүүдтэй гурвалсан гэрээ байгуулсан.

Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 61 дүгээр тогтоолын дагуу аймгийн хэмжээнд Улсын хошой аварга өрх 2, Улсын аварга малчин өрх 8, нийт 10 аварга малчин төрөн гарсан. Шалгарсан малчдын шагналыг 05 сарын 06-10-ны хооронд гардуулан өгсөн.

Мал аж ахуйн хаваржилт, цаг үеийн ажилтай танилцах ажлаар Сүхбаатар, Эрдэнэцагаан, Асгат, Наран, Дарьганга, Онгон, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян, Халзан сумдаар 6 хоногийн хугацаатай явж ажилласан. Ажиллах хугацаандаа Ерөнхий сайдын 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын А/190 дүгээр захирамжийн биелэлт, 2020 оны хаврын ангилалтын ажлын явцтай танилцаж ажиллалаа.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулж энгийн механик биологийн аргаар Сүхбаатар, Асгат, Эрдэнэцагаан, Наран, Онгон, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян, Халзан сумд, Микробиологийн аргаар тэмцэж буй Баруун-Урт, Дарьганга, Мөнххаан, Түмэнцогт сумдад явцын хяналт хийж алдаа дутагдалтай байгаа орон нутагт хэрхэн зохион байгуулж байгаа ажлын явцыг газар дээр нь үзэж танилцан заавар зөвлөмж, зарим үүрэг даалгаврыг өгч биелэлтэд нь хяналт тавин ажиллалаа. Шалгалтын явцад хяналтын талбайд тэмдэгжүүлэлт муу хийсэн, шувууны үүр, суудлыг чанаргүй хийсэн, ажлын үр дүнг буруу тооцсон зэрэг дутагдлууд илэрсэнийг засаж сайжруулах зөвлөмж өгсөн.

Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдөр батлагдсан “Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх захим арга хэмжээний тухай” 101 тоот тогтоолын дагуу 1 кг ноолуур тутамд 20000 төгрөгийн урамшуулал олгож эхлэхтэй холбогдуулан сумдын малчдын данс, овог нэр мэдээлэл зөрсөн, малчид банкны харилцах дансгүй нийт 1500 малчны мэдээллийг нягталж сумдын ХАА-н мэргэжилтэнүүдтэй холбогдон засаж залруулан ХХААХҮЯаманд мэдээллийг хүргүүлэн ажилласан.

Сумдаас мал төллөлт, том малын зүй бус хорогдолын мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр авч нэгтгэн ХХААХҮЯаманд хүргүүлсэн. 05 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар аймгийн хэмжээнд мал төллөлт 72,4%, төл бойжилт 99,1%, том малын зүй бус хорогдол 0,83%-тай явагдаж байна.

Мал эмнэлгийн газар: Аймгийн Засаг даргын 2020 оны А/297 дугаар “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалт хийх тухай” захирамжийн дагуу 9 сумын бүх өвчлөмтгий мал, Мөнххаан, Уулбаян, Түвшинширээ, Халзан сумын үхэр сүргийг вакцинжуулах ажил хийгдэж байна. 13 суманд 66 ажлын хэсэгт 50 удирдах ажилтан, 71 малын эмч, 92 туслах ажилтан, 66 жолооч, нийт 276 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2,5 сая малыг вакцинжуулахаас одоогийн байдлаар 1,4 сая мал

хамрагдаж явц 58,2 хувьтай байна. Вакцинжуулалтын явцад хяналт шалгалт хийх зорилгоор мал эмнэлгийн газраас 2 ажлын хэсэг 13 сумын мал эмнэлгийн тасаг, хувийн нэгжийн эмч нарт мал эмнэлгийн нэгдсэн цахим мэдээлэлд бүртгэсэн байдлыг хянан заавар зөвлөмжийг өгсөн, 200 гаруй малчин өрхөөр орж шүлхийн вакцинжуулалтанд хамрагдсан байдал, малын өрхийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлт, мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг сурталчилан ажилласан.

Халзан сумын мал эмнэлгийн тасаг, хувийн нэгжийн эмч нартай хамтран малчин өрхүүдээс адууны нийлүүлгийн өвчний шинжилгээнд дээж цуглуулсан.

Сүхбаатар аймгийн Халзан сумын 3, 1 багуудын 78 өрхийн 144 адууны ийлдэс, ухна, хуцны 210 цусны дээжийг цуглуулан авчирч, аймгийн мал эмнэлгийн лабораторид түргэн тестээр шинжлэхэд 13 дээж эерэг гарсан. Мөн баталгаажуулах шинжилгээг хийж байна.

Эрүүл бүсэд харьяалагдах Баруун бүсийн 7 аймаг руу амьд малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, бусад аймгуудаас амьд малын шилжилт хөдөлгөөн хориглосон талаар сумдад чиглэл хүргүүлж ажиллалаа. Шилжилт хөдөлгөөнөөр амьд мал явах тохиолдолт мал эмнэлгийн лабораторит адууны нийлүүлгийн өвчин болон бусад шинжилгээнүүд өгч хариу гарсаны дараа шилжилт хөдөлгөөн хийгдэж байна.

2020 оны 05 дүгээр сарын 01-ны өдрөөс 05 дүгээр сарын 27-ны хооронд мал эмнэлгийн цахим системээр 940 бичилт хийгдэснээс шалгасан 159, саатуулсан 13 /хориглосон газарлуу амьд мал оруулах гэсэн, зураг болон эзэн нь тодорхойгүй/ татгалзсан 10 /баруун 7 аймгийн эрүүл бүс рүү амьд малын шилжилт хийгдэхгүй байгаа/, баталгаажуулалт хийлгээгүй 0, / баталсан 725 /байцаагч болон цагдаагийн хяналтаар зөвшөөрөдсөн бичиг/ байна.

Халдваргүйтгэлийн талаар: Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан МХГазар, Авто тээврийн газраас хот хоорондын хүн тээврийн автобусанд стандарт арга зүйн дагуу халдваргүйтгэл хийлгэх хүсэлтийн дагуу Дарьганга өртөө ХХК, Хараацайн жигүүр ХХК-ний Улаанбаатар - Баруун-Урт - Эрдэнэцагаан сумдын хүн тээврийн ирэх, буцах чиглэлийн автобусыг өдөрт 3 удаа давхардсан тоогоор 575 ширхэг автобусны 378.0 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийг 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн өдөр тутам хийж байна.

Аймгийн Засаг даргын А/190 дүгээр захирамж, 13 сумын Засаг даргын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд удирдах ажилтан 29, малын эмч 49, жолооч 18, туслах ажилтан 42 нийт 138 хүний бүрэлдэхүүнтэй 14 ажлын хэсэг гарч нийтийн эзэмшлийн 1761,2 мянган м.кв талбай, зүй бусын хорогдлоор үхсэн 1907 бод, 11829 бог, 994 амьтан, нийт 14730 ширхэг хүүр сэг зэмийг нэгдсэн устгалын цэгт устгаж, устгалын цэгийн 123,2 мянган м/кв, зoorь агуулахын 95,6 мянган м/кв, 1579 хашаа хорооны 981,0 мянган м/кв, бэлчээрийн талбайн 1049,5 мянган м/кв, нийт 4010,6 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийн ажлыг хийгээд байна.

Хэнтий аймагт зохион байгуулагдаж байгаа 2-р ээлжийн эпидемиологийн судалгаа хийх дадлагад 6 малын эмч хамрагдаж байна.

Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний чиглэлээр: Аймгийн хэмжээний хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүр сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ болон холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Монгол Улсын Их хурлаас “Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлдвэрлэл үйлчилгээний тухай хууль”-ийг 2019 оны 05 дугаар сард батлаж, 2020 оны 09 дүгээр сарын 01- ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсонтой холбогдуулан Боловсрол соёлын газар, сумдын ЗДТГ, сургууль, цэцэрлэгүүдэд дээрх хуулийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгсөн.

Монгол Улсын Засгийн газраас баталсан 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 113 дугаар тогтоол болох “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт, тавих журам” –ын дагуу 2020 оны 04 сарын 20-ны өдрөөс 2020 оны 05 сарын 19-ний өдрийн 17:30 цаг хүртэл жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгжийн хүрээнд бизнес төсөл хүлээн авах зар мэдээг олон нийтэд ил тод нээлттэй зарлах ажлыг орон нутгийн телевизүүд, Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн албаар дамжуулан зохион байгуулж нийт 30 аж ахуйн нэгжийн 3,1 тэрбум төгрөгийн санхүүжилт хүссэн бизнес төслийг хүлээн авч цахим бүртгэлийн системд бүртгээд байна.

“Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт, тавих журам” –ын дагуу төсөл сонгон шалгаруулах дэд хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулах тухай албан бичгийг жижиг дунд, үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 7 төрийн бус байгууллагад хүргүүлж, нийт 5 төрийн бус байгууллагаас 6 төлөөллийн материалыг хүлээн авч журмын дагуу шаардлага хангасан төлөөлөл бүхий “Дэд хороо”-г Аймгийн Засаг даргын А/351 дүгээр захирамжаар байгуулсан.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “BEST” төслөөс санаачлан Авлигатай тэмцэх газар, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан хамтран аймгийн АЗДТГ, ХХААГазрын асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан “ЖДҮ-ийг дэмжих зорилгоор төрөөс олгож байгаа санхүүжилтийн үйл ажиллагаанд нээлттэй, ил тод шударга байдлыг хангах нь” сургалтад холбогдох мэргэжилтнүүд хамрагдаж бизнес төсөл хэрэгжүүлэхээр зорьж буй аж ахуй нэгжид мэдээлэл хүргэн ажиллалаа.

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх эрх бүхий 13 аж ахуй нэгжийн үйл ажиллагааг сунгах, 2 аж ахуй нэгжийн шинээр үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг хүлээн авч аймгийн Засаг даргын 2020 оны А/344 дүгээр захирамжаар баталгаажуулж тусгай зөвшөөрлийг олгоод байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” ТТ-9751 төслийн хүрээнд бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилго бүхий цахим катологи боловсруулах ажлын талаар уг ажлыг гүйцэтгэх компанийн удирдлагууд, Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, санал солилцсон.

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас хэрэгжүүлэхээр зорьж буй бизнесийн салбарын салбарт үзүүлэх зөвлөх болон техник туслалцааны төлсийн хүрээнд Сүхбаатар аймагт нэн тэргүүнд зөвлөх үйлчилгээ, техник, тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлага өндөр байгаа бизнесийн салбарын нөхцөл байдлыг тодорхойлон МҮХАТанхимд хүргүүлээ.

Уул уурхайн чиглэлээр: Эрдэнэцагаан сумын 6-р багийн нутагт хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагааг таслан зогсоож, харуул хамгаалалтыг хариуцан ажиллаж байгаа ажлын хэсгийн харуул хамгаалалтын ажлын хугацаа сунгах, ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, хоол хүнс, түлш шатахуун, томилолтын зардлыг шийдвэрлүүлэх талаар Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гарган ажиллалаа.

Түүнчлэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, БОАЖЯ, АМГТГ-т орон нутагт үүсээд буй нөхцөл байдал, цаашид орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах зардлыг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран ажиллах, чиглэл авах тухай албан бичгийг хүргүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/359 дүгээр захирамжаар 2019 онд нутгийн захиргааны байгууллага ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай нийгмийн хариуцлагын хүрээнд байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангуулах, аймгийн 2020 оны төсвийн орлогыг бүрдүүлэх чиглэлээр аж ахуй нэгжүүдтэй хэлцэл хийх, гэрээ байгуулах ажлын хэсгийг байгуулан аж ахуй нэгжүүдэд чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/298 дугаар захирамжаар ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Бага өлгий”, “Сэвүүн уудам тал” ХХК-уудад олголоо.

ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн “Эрдэс плазм” ХХК-ийн өргөдлийг аймгийн ИТХТ-ээр хэлэлцүүлэн 22 дугаар тогтоолоор дэмжсэн саналыг авсан.

ОҮИТБ-ын Засаглалыг сайжруулах ажлын албанаас зохион байгуулсан цахим сургалтад Санхүү, төрийн сангийн хэлтэс, ХОХБТХ-ийн холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан.

Зам тээврийн чиглэлээр: Баруун-Урт сумын 1-р баг “24, 60 айл”-ын орон сууцнуудын гаднах зам, талбай, “Грийн таун” хорооллын баруун талаар урагшаа музейн урд талын 2-р тойргийн авто зам хүртэлх зам, замын байгууламжийн техникийн тодорхойлолт, аймгийн Авто тээврийн төвийн авто вокзалын гаднах талбайн засвар, 1-

р багт хийгдэх 420 у/м явган замын ажлын техникийн тодорхойлолтыг тус тус боловсруулан батлуулж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн.

2019 онд инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх зайлшгүй шаардлагаар аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг сэтэлж, нөхөн сэргээлтийг дутуу, чанаргүй хийсэн 6 аж ахуй нэгжид авто замын нөхөн сэргээлтийг технологийн дагуу чанартай, түргэн шуурхай хүргэх тухай албан мэдэгдлийг хүргүүллээ.

Энэ сард 3709 тээврийн хэрэгсэл техникийн хяналтын үзлэгт хамрагдсан дүн мэдээтэй байна.

Зорчигч тээвэр: Улаанбаатар хотоос Сүхбаатар аймаг чиглэлд автобусаар 1243 зорчигч, Сүхбаатар аймгаас Улаанбаатар хот чиглэлд автобусаар 1446 зорчигч зорчсон байна.

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Авто замын уулзварын гэрлэн дохио /Сүхбаатар, Баруун-Урт сум/”, ЗТХЯ/202002002 дугаартай тендерт хамгийн сайн үнэлэгдсэн “Инносолоюшн” ХХК-д, “Хөл бөмбөгийн талбайн гаднах авто зогсоол”, СБАОНӨГ/202001018 дугаартай тендерт хамгийн сайн үнэлэгдсэн “Ханан салхит” ХХК-д үнэлгээний хорооноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлсэн.

Авто тээврийн салбарын 95 жилийн түүхэн ой тохиолдуулан Зам тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу сумд, агентлаг, албан байгууллагаас авто тээврийн салбарт үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагч, иргэдийг төрийн болон яамны шагналд тодорхойлох материалыг хүлээн авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Эрчим хүчний чиглэлээр: Өндөрхаан-Баруун-Уртын 110кВ-ын ЦДАШ засвар, Халзан, Онгон сумын 35кВ-ын ЦДАШ-ын урсгал засвар цэвэрлэгээ, Уулбаян сумын 35кВ-ын ЦДАШ тулгуур №363 солих, Сүхбаатар сумын 10кВ-ын ЦДАШ-ын тулгуур солих тэгшлэх ажил, Наран, Дарьганга сумын 15кВ-ын ЦДАШ-ын цэвэрлэгээ, чангалгааны ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн ба Мөнххаан сумын 1км 0.4кВ-ын ЦДАШ-ын шинэчлэл хийсэн байна. Мөн 10 дэд станцын гадна хамгаалалтын хашаа хийж, 110/35/10кВ-ын Баруун-Урт дэд станц, сумдын ХБ-ын реле хамгаалалтын туршилт тохируулга, Онгон, Наран, Дарьганга сумын 220Вт-ын 1200ш тоолуурын баталгаажилт хийгдсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

Хог хаягдлын талаар: Баруун-урт сумыг тойрсон эзэнгүй хог хаягдал, Долоон худгийн хогийн цэгийн асуудлыг Баруун-урт сумын ЗДТГ-аас 1.6 сая төгрөг шийдэж түрэлтийн ажил 5 хоног хийж, 2 хоног гадна талд үүссэн хогийг далангийн дотор талд оруулж асгах, ХХҮГ-аас 10 хүн 3 хоног ажиллаж малын сэг зэм, гялгар уут зэргийг цэвэрлэж дуусгасан. Мөн Дарьганга суманд төвийн нийтийн эдэлбэр газрын эзэнгүй хог хаягдал, сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулж Сумын төвөөс хааш хаашаагаа 3 км газарт 10 хүнийг 7 хоногийн хугацаатай ажиллуулж нийт 5 тн хог, 15 бод, 18 бог малыг устгалын цэгт хаяж устгасан.

Сумдын хог хаягдлын цэгийг цэгцлэх ажлыг сүүлийн 2 жилд шат дараатайгаар авч хэрэгжүүлж байна. Энэ жил Түмэнцогт, Уулбаян, Асгат, Халзан, Наран сумдтай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Наран суманд хог хаягдлыг цэгцлэх ажилд сумын ЗДТГ-ын албан хаагчид хамрагдан төв зам дагуух хог хаягдал болон сэг зэм зэргийг цэвэрлэж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Нийт 270 бог, 50 бод малын сэг зэм цэвэрлэсэн бөгөөд мал эмнэлгийн газраас 340,000 төгрөг, Засаг даргын нөөцөөс 200,000 төгрөгийн зардал, нийт 540,000 төгрөгийг зарцуулсан. Мөн хогийн нэгдсэн цэгт 3 ширхэг анхааруулах самбар, сумаас 5км-т ногоон бүс гэсэн тэмдэглэгээг байршуулаад байна.

Онгон сум Нийтийг хамарсан төслийн хүрээнд сумын 4, 5-р багийн Засаг дарга нартай хамтран 10 хоног сумын төвийн эргэн тойрон 3км-ийн радиуст эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. Мөн хогийн цэгийн салхин доод талд хог хаягдал хийсэхээс сэргийлж 800 м газарт тор татах ажлыг хийсэн байна.

Дархан хаан уулын тахилга болохтой холбогдуулан уулын хог хаягдлыг цэвэрлэж, нэгдсэн хогийн цэгийн тэлсэн 6 га хог хаягдлыг 3 га болгож отвальдож түрүүлэх ажлыг 4 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхэд 3.0 сая төг зарцуулаад байна. Мөн Эрдэнэцагаан сумын хогийн нэгдсэн цэгт 120тн хог хаягдлыг түрж цэгцэллээ.

Хоггүй цэвэрхэн монгол аяны хүрээнд БОАЖЯ-ны хэвлэл мэдээллийн албатай хамтран аяны хүрээнд орон нутагт хэрэгжүүлсэн ажлын талаар танилцуулга нэвтрүүлэг бэлтгэж ажиллалаа. Нэвтрүүлэгт ХОХБТХ, Тохижилт үйлчилгээний газар, БНМТ сав газрын захиргааны албан хаагчид оролцож аяны хүрээнд хамтран хэрэгжүүлсэн ажил, аяны үр дүнгийн талаар ярилцлага өгч шаарлагатай мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Аймгийн төвлөрсөн хогийн цэгийн урд тал Халзан, Баяндэлгэрийн зам дагуу эзэнгүй үүсээд байсан хогийн цэгийг цэвэрлэж, зам дагуу мэдээллийн самбар, камер байршууллаа. Ингэснээр жил бүр эзэнгүй үүсээд байдаг хог хаягдал буурах юм. Уг ажлыг аймгийн БОАЖГ болон Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨҮГ-тай хамтран гүйцэтгэсэн бөгөөд 800.0 мянган төгрөг зарцуулагдсан байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар: Улсын онцгой комиссын 01 дүгээр албан даалгавар, БОАЖСайд, Шадар сайдын хамтран баталсан 12/А/51 тоот тушаал, аймгийн Засаг даргын 02 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Асгат сумын Өлзийт, Дөхөм, Их уул, Жаргалант багийн түймрийн эрсдэлтэй газарт нутаглаж байгаа 143 өрх, 196 жолоочид 400ш брошур болон анхааруулах санамж, өгч гарын үсгийн баталгааг авч ажилласан байна.

Мөн Сүхбаатар суманд 325, Эрдэнэцагаан суманд 450 иргэнээс гарын үсгийн баталгаа авч, урьдчилсан сэргийлэх ажил хийгдэж байна.

БОАЖГ-аас ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Сүхбаатарын өнгө” сонинтой хамтран мэдээлэл бэлтгэж 600 хувь сонинг хэвлүүлэн эрсдэл бүхий сумдад тарааж ажиллалаа.

БОАЖГ, Скайтел, УЦУОШГ-тай хамтран 4/25-6/25 хооронд түймрийн эрсдэл бүхий Эрдэнэцагаан, Асгат, Дарьганга, Сүхбаатар, Түмэнцогт, Мөнххаан сумын 2680 өрхийн иргэдийн гар утсанд масс мессеж мэдээг 7 хоног бүр хүргэж байна.

БОАЖГ-ын даргын удирдамжаар хээрийн түймрийн эрсдэл бүхий 6 сумын байгаль хамгаалагч нарт хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, эргүүл хяналт хийх зорилгоор 6 сарын хугацаанд сар бүр 20 л шатахуун олгох ажил тогтмолжсон.

Байгаль хамгаалах ахмадын нөхөрлөл. Түмэнцогт сумын ЗДТГ, Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Түмэн барбарис Байгаль хамгаалах нөхөрлөл хамтран Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалтыг 190 гаруй малчид иргэдэд явуулын хэлбэрээр хүргэж ажилласан байна.

Ойн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: “Аймгийн төвийн ногоон байгууламжинд тарьсан модны усалгаа, арчилгааг хийж ургуулах” ажлыг 50 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын тендерийг зарлаад байна. Нийт 16 байршил бүхий газруудад ургаж байгаа 23414 ш мод сөөгний усалгаа, арчилгааны ажлын тендерийг 4 багцтайгаар зохион байгуулахаар зарлаж, БОАЖГ-ын даргын 2020 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан Үнэлгээний хороо шалгаруулалтыг хийж гүйцэтгэчийг шалгаруулаа.

Гүйцэтгэгчээр “Сүхбаатар-Ойжуулалт” СДОАнги, “Ойжуулалт-Хайлааст” ХХК, “Шаргын модод цэцэрлэг” ХХК-ууд шалгарч гэрээ байгуулан, нийтийн эзэмшлийн 11 байршил бүхий газарт ургаж байгаа нийт 23414 ширхэг 10 төрлийн мод сөөгийг арчилан ургуулах ажлыг гүйцэтгэх ажыг эхлээд байна.

“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг “Хандлагаа өөрчилж хашаандаа мод таръя” уриан дор” БОАЖГ, Сүхбаатар-Ойжуулалт” СДОАнги хамтран зохион байгуулж Баруун-Урт сумын 3,4,7-р багуудын иргэдэд мод суулгацыг хүргэж ажилласан. Захиалга өгсөн иргэдэд хаягийн дагуу мод суулгацыг гарын авлагын хамт хүргэн өгч төрийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь шуурхай байдлаар хүргэж ажиллалаа.

Усны нэгдсэн менежментийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: “Баруун-Урт голын хамгаалалтыг үргэлжүүлэн шинэчилж дуусгах” ажлын тендерт шалгарсан “Тохижилт-Үйлчилгээ” ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулж, эхний ээлжийн санхүүжилт 40% буюу 10 320 834 төгрөгийн санхүүжилтийг олголоо. Баруун-уртын голын эхийг хамгаалах тендерт Сүхбаатар тохижилт ОНӨАТҮГ шалгарч модны тайралт, хашаа хамгаалалт хийх ажил эхлээд байна.

Баыгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлуулах талаар мах боловсруулах үйлдвэр, цэвэр усны үйлдвэр эрхлэгчдэд сургалт зохион байгууллаа. Сургалтад нийт 8 ААН хамрагдаж тодорхой ойлголт мэдээллийг авлаа.

2020 онд усны тооллого, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийг тогтоох ажлын төлөвлөлтийн хурлыг зохион байгуулж, ДБХСан, ХГСГЗ, БНМСГЗ, УГХГДТСГЗ, ГӨДСГЗ-аас нийт 19 хүн оролцсон байна. Хурлын үр дүнд 2017 онд хийгдэж дуусгаагүй усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийг тогтоох ажлыг үргэлжлүүлэн хийж дуусгах, ХБ-ийн хүснэгтэн мэдээллийг хүснэгтийг нэг загвараар гаргах, усны тооллогыг хосолсон аргаар хийх зэрэг үр дүнд хүрлээ.

Аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлсэн ажил: “Сүхбаатар аймаг дахь чулуун дурсгалуудыг бүртгэх тухай” аймгийн Засаг даргын 2020 оны А/278 дугаар захирамжийн дагуу ажлын хэсэг томилогдож, Сүхбаатар сумын Дарханхаан уул, Нийгмийн хонгор цогцолбор, Улаан хошууны хавцалын булш, Эрдэнэцагаан сумын Дугнагарын хүн чулуу, Хөндлөн хавцалын тамгатай хад, Хавх толгойн хүн чулуу, Лхачинвандад уулын дөрвөлжин булш, зэл чулуу, Цайдамын нуурын хадны зураг, Дарьганга сумын Өрөм хүрэмийн нуурын хүн чулуу, Хадатын булгийн хүн чулуу, Наран сумын Мандалын хүн чулуу, Логийн чулууны Ганзайн хадны зураг, Онгон сумын Будрын чулууны хадны зураг, Шивээтийн хүн чулуу, Баяндэлгэр сумын Өлзийт булгийн хадны зураг, Мандалын овооны хадны зураг, тамга, Түвшинширээ сумын Донгойн ширээ цогцолбор, Цагаан элэгний хадны зураг, Бичигт хад, Уулбаян сумын Хангайн гэдэг газрын хадны зосон зураг, Мөнххаан сумын Богд уулын зүүн талын дөрвөлжин булш зэргийг аймгийн бүртгэл мэдээллийн санд бүртгэж баримтжууллаа. Ажлын хэсэг явах хугацаандаа Эрдэнэцагаан сумын Цайдамын нуурын баруун хойд талд шинээр хадны зураг, Лхачинвандад ууланд 20-30 дөрвөлжин булш, зэл чулуу, Харгилтайн голын эхээс дөрвөлжин булш, Онгон сумын Будрын чулуунд шинээр улаан зосон хадны зураг нийт 2 хадны зураг, 20-30 гаруй дөрвөлжин булш, 1 зэл чулууг илрүүлсэн байна.

Зургаа. Бусад салбарт хийгдсэн ажил:

Мэргэжлийн хяналтын газар: Дөрвөлж /ОНӨ/ ХХК-д байгаль орчин, эрчим хүч, хөдөлмөрийн эрүүл ахуйн, авто тээвэр, өргөх механизм, хөдөлмөрийн хяналт, барилгын техникийн хяналт, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалт хийж 49 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, 1000 нэгжээр торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Хяналтын 7 чиглэлээр 11 аж ахуй нэгжид төлөвлөгөөт шалгалтыг хийж шалгалтын явцад зөрчил дутагдал гаргасан 1 аж ахуйн нэгжид 500.0 мян төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож ажилласан.

Дарьганга, Онгон, Наран, Халзан, Мөнххаан сумдад эрчим хүч, барилга, хэмжил зүйн хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Онгон, Халзан сумдын ЗДТГ, Тэс петролиум ШТС, Мөнхжин ШТС төлөвлөгөөт шалгалт, Ээж баян ЗГБХН, Баруун-Урт сумын ЗДТГ зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

“КМС констракшн” ХХК-тай хамтарч “ДБЭХС” ТӨХК-ний Сүхбаатар салбар, “Дөрвөлж” ОНӨҮГ-ын авто крануудад 2020 оны ээлжит техникийн магадлал хийж, краны оператор, оосорлогч-дохиочин, аюулгүй ажиллагаа хариуцагчдын давтан сургалт зохион байгуулсан.

ДЦН ХХК-аас ирүүлсэн өргөдлийн дагуу 2020.05.14-15-ны өдрүүдэд Түмэнцогт суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Эф жи пи эм ХХК, Монголжүюаньли ХХК -уудад төлөвлөгөөт бус шалгалт хийж, Эф жи пи эм ХХК-ийн олборлолтийн үйл ажиллагааг, Монголжүюаньли ХХК-ийн Уулбаян-Түмэнцогт чиглэлийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг улсын байцаагчийн актаар түр хугацаагаар зогсоож, шалгалтын ажил үргэлжлэн хийгдэж байна.

Мал эмнэлгийн хяналтын чиглэлээр 01/85 тоот удирдамжийн хүрээнд 5 сумын 12 аж ахуй нэгж тандалт судалгаанд хамруулсан.

Зах зээлд худалдаалагдаж байгаа малын эмийн худалдаалалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 6 сумын 13 аж ахуй нэгж хамрагдаж монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй 1, хугацаа дууссан 1 малын эмийг хураан авч мэдээллийг холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан шинээр баригдаж байгаа барилга байгууламжид урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай 01/17 тоот удирдамжийн дагуу Баруун-Урт суманд 960 хүүхдийн сургуулийн барилга угсралтийн ажил гүйцэтгэж байгаа “Эм би би си” ХХК, 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтийн ажил гүйцэтгэж байгаа “Наран булаг трейд” ХХК, Цагдаагийн 20 айлын орон сууцны барилга угсралтийн ажил гүйцэтгэж

байгаа “Геоканон төв” ХХК, 100 айлын цогцолбор орон сууцны барилга угсралтийн ажил гүйцэтгэж байгаа “Будаймонд” ХХК, 16 давхар үйлчилгээ, оффисын барилга угсралтийн ажил гүйцэтгэж байгаа “Ди жи фрийндс” ХХК-уудад урьдчилан сэргийлэх шалгалтыг Хөдөлмөрийн эрүүл ахуйн, хөдөлмөрийн хяналт, барилга техникийн хяналт, эрчим хүч, тээвэр /өргөх машин механизм/-ийн хяналтын чиглэлээр хамтран холбогдох инженер техникийн ажилтнуудыг байлцуулан хийж гүйцэтгэсэн. Илэрсэн дутагдлыг арилгуулахаар 32 заалттай 4 албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан. Шалгалтын үр дүнд барилгын талбайн эмх цэгцийг хангуулж, хог хаягдлыг ачуулж, ажилчдын орох гарах гарцын аюулгүй байдлыг хангуулсан. Ажилчдын хооллох гал тогоог ажилчдын байрыг тусад нь болгуулж, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн.

Covid 19-той холбоотой ажилчдын хоол хүнсний аюулгүй байдалтай холбоотой улсын байцаагчийн 17 заалт бүхий зөвлөмж хүргүүлж биелэлтийг тооцож ажилласан. Хийсэн ажлын тайлан мэдээг зургаар баримтжуулж ирүүлэх талаар ААНБ-дад үүрэг чиглэл өгч, гар угаах санамж 5 ААНБ-д 30 ширхэгийг өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэргэжил арга зүйн зөвлөмж зөвлөгөө өгсөн.

Эрдэнэцагаан сумын Төмстэйн ширээт гэх газарт зөвшөөрөлгүй алт олборлолт хийх гэж буй иргэдэд хяналт тавихаар аймгийн Цагдаагийн газар, Тагнуул, сумын ЗДТГ-тай хамтран ажилласан.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд аймгийн ЗДТГ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, аймгийн цагдаагийн газар, гэр бүл, хүүхэд, залуучуудын газартай хамтран ажиллаж Сүхбаатар аймгийн ХАБЭА-н мэргэжилтнүүд, Мэргэжлийн хяналтын газрын фэйс, пэйж хуудсаар 3 төрлийн видео шторк, 6 төрлийн анхааруулах зөвлөмж, сэрэмжлүүлэгийг олон нийтийн цахим хуудсаар түгээн ажилласан. Мөн 6 төрлийн гарын авлагыг аж ахуйн нэгж байгууллагуудад тарааж, “Ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтыг хориглох урьдчилан сэргийлэх” уриан дор аж ахуйн нэгж байгууллагаас санал асуулгыг авч ажилласан.

Хананфитнес ХХК-д хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж улсын байцаагчийн 8 заалттай зөвлөмж хүргүүлсэн.

Бичигт боомтоор байгалийн эрдэс баялаг экспортлох бэлтгэл ажил хангагдсан.

МХЕГ, ЭМДЕГ газартай хамтарсан 01/122 удирдамжийн дагуу эрүүл мэндийн даатгалын сан болон сангаас санхүүжиж буй эрүүл мэндийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх хамтарсан шалгалт хийгдэж байна.

МХЕГ газрын даргын баталсан 01/27, 01/102 дугаартай удирдамжийн хүрээнд Баруун-Урт суманд улсын болон хувийн хөрөнгө оруулалттай барилга байгууламжийн барилга угсралтын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалтыг хийж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 107 заалттай 4 албан шаардлага хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Сумдын ЗДТГ-т КОВИД-19 халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сум суурин газрын хог хаягдлын цэвэрлэгээг хийлгэх, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг тогтмолжуулах талаар газрын даргын албан тоотыг хүргүүлж ажилласан.

“КОВИД-19”-ийн халдвараас урьдчилан сэргийлэх дадлага сургуулилтыг амжилттай зохион байгууллаа. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 6 суманд тандалт хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч ажилласан.

Ерөнхий боловсролын сургуулиудын 12-р анги төгсөлтийн давтлага эхэлсэнтэй холбогдуулан 9 сургуульд 27 заалттай зөвлөмж хүргүүлэн биелэлтийг ханган ажиллаж байна.

“Хөрсөө хойч үедээ хэвээр үлдээ” сарын аяны хүрээнд 8 заалттай төлөвлөгөө гарган биелэлтийг хангуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

“Зөв дадал-Ногоон ирээдүй” цахим сарын аяны хүрээнд 9 заалттай төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Нөлөөллийн арга хэмжээний хүрээнд 14 төрлийн постор бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулж, 880 хүний хандалт авсан байна.

Стандарт, хэмжилзүйн хэлтэс: Стандартчилал, техникийн зохицуулалт, итгэмжлэлийн тохирлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилт, Үндэсний стандарт 291-д өгөгдөж, Стандартчилал хэмжилзүйн газрын тогтоол, журам, дүрэм, Аймгийн засаг даргын

захирамж, Хэлтсийн даргын үүрэг даалгавар зэргийг бүрдүүлж эхний улирлын байдлаар 85 гаруй аж ахуй нэгжийн худалдаа үйлчилгээний газар тохирлын үнэлгээнд хамрагдсанаас: хүнсний дэлгүүр-25, минимаркет-23, Зоогийн газар- 11, пав караоке-20, тус тус тохирлын гэрчилгээ олголоо.

Оүйөөсүгэй далайд: Тайлант хугацаанд иргэн аж ахуй нэгж байгууллагаас өдөр тутам ирэх хэмжих хэрэгсэл баталгаажуулах, шалгалт тохируулга хийлгэх санал хүсэлтийг хүлээн авч барагдуулан ажилласан. Энэ ажлын хүрээнд электрон болон механик жин-124, цусны даралтын аппарат-74, цахилгаан тоолуур-450, түгээгүүр -45, лабораторийн жин-6, тус тус баталгаажуулалт, шалгалт тохируулганд хамруулан ажилласан.

Шинэ болон шинэчлэгдэн батлагдсан стандартаар 2 байгууллагад үйлчилж 2 стандартаар хангасан

Долоо. Сумдад зохион байгуулагдсан ажил:

Асгат:

Төрийн удирдлагын чиглэлээр: Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгааны ажлын 4 хэсгийг томилон ажиллуулж байна.

Улсын хошой аварга, улсын аварга малчин, аймгийн аварга малчин, аймаг, сумын алдарт уяачдын шагналыг гардуулах ажлыг зохион байгууллаа.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Гэр хорооллын айл өрхийн муу усны нүх, жорлон 720м² нийтийн эзэмшлийн талбай 34,000м² хашаа хороо 285, малын хүүр сэг зэм 633, нийт 110252 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Сум хөгжүүлэх санд 12 иргэний төсөл ирсэнээс 7 төсөл дэмжигдэн 39,8 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэлээ.

Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулж энгийн механик аргаар 3 хэсэгт 8000 га газар хийсэн ба малчин өрх 65, иргэн төрийн албан хаагч 15, тээврийн хэрэгсэл 38 тус тус дайчлан ажилласан.

Байгаль орчин:

Асгат сум ,залуучуудын холбоо, сургууль ,цэцэрлэг, хүн эмнэлэг зэрэг нээлттэй группт 5 удаа сэрэмжлүүлэг мэдээ байршуулж веб сайтаар мэдээллийг ард иргэдэд өгсөн. Мөн цаг уурийн харуултай хамтран хуурайшилт ихтэй салхитай цаг үеийн мэдээ масс мессежийг 6 удаа хөдөөгийн малчдын гар утсанд хүргэж ажилласан.

Бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд нийтийн эзэмшил талбайд 150 мод тарьж 3 байгууллага 49 хүн оролцож 323500 төгрөгийн зардал гарган ажилласан

Боловсрол : 05 сарын 21-ний байдлаар нийт 242 сурагчдаас 171 суралцагч буюу 70,7% -нь теле хичээлийг үзэж байна. Үүнээс цахимаар багштайгаа холбогдож теле хичээлээ тогтмол шалгуулж байгаа 90 суралцагч, утсаар холбогдож байгаа 81 суралцагч байна. Өмнөх долоо хоногийн хичээл үзэлтээс сурагчдын хувь буурсан.

Соёлын төв: Номын сангийн үйлчилгээг цахимаар хүргэж 3 тууж 22 өгүүллэгийг Соёлын төвийн цахим групп дээр тавьж нийтэд хүргэсэн.

“Цэцэн хүүхэд” түргэн хэллэгийн тэмцээнийг цахимаар зохион байгуулж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Зорилтот бүлгийн арвин ургац бүлгийн гишүүд 1 га газар төмс, хүнсний ногоо тариалсан байна. Мөн зорилтот өрхийн 10 гишүүнээр мод тарих сумын төвийн ойр орчмын хог түүх ажлын гүйцэтгүүлэв.

Баруун-урт:

Байгаль орчин, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын чиглэлээр: Аймгийн ГХБХБГазартай хамтран 9-р багийн нутаг дэвсгэр дэх унасан хашааны эзэн холбогдогчийг тогтоож хамтран янзалсан. Тус багт цамхагт гэрэлтүүлэг суурилуулах ажлын тендерийг зарлан, сонгон шалгаруулж “Алсын солонго” ХХК-тай гэрээ байгуулсан.

Тохижилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Уртын гэгээ”, Сүхбаатар тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазарт тус тус нэг машины парк шинэчлэлт хийсэн байна.

2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрын дуудлага худалдаа ШТС-ын зориулалтаар зохион байгуулсан.

1-р багийн нутаг дэвсгэрт Дөрвөлж 12 айлын дээврийн засварын ажил эхлүүлсэн.

Аймгийн ХХҮГ-тай хамтран нийтийг хамарсан ажлын хүрээнд 20 иргэнийг түр ажлын байраар хангасан.

Хотын төвөөс мал гаргах ажлыг аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж 8 багийн 63 өрхийн 307 малыг гаргасан.

Таван эрдэнэ малтай хорооллын хогийн нэгдсэн цэгийг цэгцлэх ажлыг Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-тай хамтран хийж гүйцэтгэсэн.

Ус бохирдуулсны тухай хуулийн дагуу Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаанаас 60 байгууллагын усны дүгнэлтийг хийж Засаг даргын зөвшөөрөл олгосон.

Аймгийн МХГ-аас “Зөв дадал-Ногоон ирээдүй” сэдэвт сарын аяны хүрээнд байгаль орчныг хамгаалах, ард иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр ажлууд зохион байгуулж иргэдэд мэдээллийг цахимаар болон орон нутгийн телевизээр өгсөн.

Эзэнгүй хогийн цэгийг булаж устгах, малын сэг зэмийг түүх ажлыг аймгийн БОАЖГ, мал эмнэлгийн газартай хамтран хийж нийт 120 м2 хог, 150 малын сэг зэмийг булаж устгасан.

Мод тарих өдрийн хүрээнд Баруун-Урт сумын хэмжээнд айл өрхүүдэд 1000 ш мод тарьж, 3 мэргэжлийн байгууллага 2200 модны нөхөн тарилт хийсэн байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын хэмжээнд 116221 мянган толгой эх мал төллөж, 115861 мянган толгой төл мал хүлээн авч төл бойжилт 91% тай байна. Том малын хорогдол 2236 гараад байна.

Хагас жилийн малын түүвэр судалгаа явуулах 3 групп гарч сумын хэмжээнд сонгогдсон 9 багийн 210 өрхөөр орж мал тооллого хийж байна.

Газар тариалан эрхлэх сонирхолтой 10 иргэнтэй гэрээ байгуулан агро паркийн 1 га талбайд төмс, нарийн ногоог суулган хаврын тариалалтыг эхлүүлээд байна.

Ноолуурын урамшуулалд хамрагдах тус сумын 9-н багийн малчин, мал бүхий 1179 өрхийн ноолуурын урамшуулал орох дансны мэдээллийг авч нэгтгэн ХХАА-н газарт хүргүүлсэн.

Цаг үеийн ажлууд: 2020 оны 5 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд УЦУОШТ-өөс урьдчилан мэдээлсэний дагуу цаг агаарын гамшигт үзэгдлээс сэргийлэх анхааруулга постер мэдээллийг цахимаар түгээж 5053 иргэдэд хүргэсэн. Иргэдэд чанга яригчаар сэрэмжлүүлэг мэдээллийг бүх нутаг дэвсгэрт явж хүргэв. Мөн малчин болон мал бүхий 918 иргэнд утсаар холбогдож сэрэмжлүүлэг мэдээ хүргэж ажилласан.

Баяндэлгэр:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын засаг даргын 2020 оны А/44 дүгээр захирамжаар тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл техникийн хяналтын үзлэгийг 05 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд зохион байгуулсан.

Сумын засаг даргын 2020 оны А/46 дугаар захирамжаар үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан эх хэлээ эрхэмлэн дээдлэх бичиг соёлын дурсгалаа сурталчилах үндэсний бичгийн хэрэглээ мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор төрийн албан хаагчид иргэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Сайхан бичигтэн” уралдааныг цахимаар зохион байгуулж шагналын санг Засаг даргын нөөц сангаас шийдвэрлэлээ.

Аймаг орон нутгийн хөгжлийн сангийн 17.5 төгрөгийн хөрөнгөөр Нийтийн ахуй үйлчилгээний барилгын ажлыг гүйцэтгүүлж, ашиглалтанд хүлээн авсан.

Тамгын газар:

Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд: “Өөрийнхөө болон бусдын төлөө амны хаалтаа зүүцгээе” аяныг улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан цахимаар уриалга мэдээлэл зөвлөмжийг өгч ажиллаж байна.

ЕБСургууль: Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлүүлээ.

БСШУСЯ, Япон улсын ЗГ, Дэлхийн банк, ХИСангаас хамтран 5 аймгийн 25 суманд 2019-2023 онуудад 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж буй ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчид, сургууль завсардсан ажилгүйдэлд өртөх эрсдэлтэй 14-25 насны хүүхэд

залуучуудад энтрепренер чиг баримжаатай хувь хүний ур чадвар эзэмшүүлэх, өөрөөр хэлбэл орчин үеийн хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай суурь ур чадварууд эзэмшин, сургуулиас ажлын байранд амжилттай шилжихэд нь хүүхэд залуучуудад бодит дэмжлэг болох төсөл арга хэмжээнд хамрагдсан.

Эрүүл мэндийн төв: Нийт үзлэгт 1419 хүн хамрагдсан. Гэрийн идэвхитэй эргэлт-74, Идэвхитэй хяналт- 126, Урьдчилан сэргийлэх үзлэгт- 796, Амбулаториор 397, Больницод хэвтэн эмчлүүлсэн нийт 25 хүнээс хүүхэд 17.

Сэргээн засах эмчилгээний кабинетаар нийт 48 хүн иргэн, Лабораториор 245 иргэн үйлчлүүлсэн. Амбулаториор үйлчлүүлж буй иргэдэд коронавирусын талаар зөвлөмж өгч гарыг ариутгаж байна.

Соёлын төв: Сумын ард иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, урлаг соёлын идэвхийг нэмэгдүүлэх үүднээс “Алдарт дуучин П. Адарсүрэнгийн дууг хэн сайн дуулах вэ?” дууны цахим уралдааныг зарлаж дүгнэлээ.

Эх үрсийн баярыг угтан хүүхэд багачуудын дунд “Аялгуут нас” цахим уралдааныг 3 насны ангилалаар зарлаад байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, БСУГ, БОАЖГ-тай хамтран үл хөдлөх түүх дурсгалын тооллогын комисс шинээр илэрсэн түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг үзэж, тоолж, бүртгэн баримтжууллаа.

Соёлын төвийн номын сан нь хорио цээрийн дэглэмээс шалтгаалж гэрээр болон цахимаар уншигчдад үйлчилж байна. Байгууллагын цахим хаягт өгүүллэг туужуудыг цувралаар оруулж уншигчдад 160 ном гэрээр олголоо.

Цэцэрлэг: Нийт 24 цахим, зөвлөгөө бэлтгэн хүргэсэн бол байгууллагын цахим хуудсанд 157 мэдээ мэдээллийг тавьж эцэг эхчүүдэд түгээсэн байна. Мөн бүлгийн багш нар 10 номын богц аялуулж сумын төв дээр байгаа бүлгийн 90 гаруй хүүхдэд аялуулсан.

Үндэсний бичиг соёлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан сумын ЗДТГ-аас зохион байгуулсан “Сайхан бичигтэн” шалгаруулах уралдаанд байгууллагаас 10 албан хаагчийг оролцуулан “Монгол бичгийг дээдлэгч байгууллага”-аар шалгарч, аргагүйч Т.Мөнхзул 2-р байрт шалгарсан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Сумын засаг даргын 2020 оны А/47 дугаар захирамжаар үлийн цагаан оготнотой энгийн механик биологийн аргаар тэмцэх ажлыг Төв, Дөхөм, Ширээт багийн 10 мянган га бэлчээрийн талбайд зохион байгуулсан.

Сумын засаг даргын А/56 дугаар захирамжаар үржлийн малд үзлэг ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалт хийх ажлыг эхлүүлж, 362 өрхийн үхэр- 8312, хонь-93903, ямаа-67707, бүгд-169922 мал вакцинжуулаад байна. Энэ нь сумын нийт өвчлөмтгий малын 35,1% нь болно.

Байгаль орчны чиглэлээр: “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг тохиолдуулан “НЭГ МОД –НЭГ НАСНЫ БУЯН” уриалгыг 18-35 насны залуучуудад нэгдэхийг уриалан цэцэрлэгт хүрээлэнгийн өргөтгөсөн талбайд 600 ширхэг модыг тарив. Мөн сумын хэмжээнд ургаж байгаа 1220 ширхэг моднуудын тайралт тандалтыг хийж нөхөн сэргээлт, усалгаа арчилгааг хийж гүйцэтгэв.

Дарьганга:

Төрийн удирдлагын чиглэлээр: Сумын Засаг даргын дэргэдэх Хил хамгаалахад туслах хүчний зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу хил хамгаалахад туслах хүчний гишүүнээр 9 иргэнийг сумын Засаг даргын захирамжаар томилж, баталгаажууллаа.

Авто техникийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын захирамжаар томилон ажиллуулж нийт 350 тээврийн хэрэгсэл хамруулан татварт 7.000.000 төгрөгийг төвлөрүүлэхээс 10.643.679 төгрөг төсөвт төвлөрүүлэн ажилласан.

Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын дагуу Үйлчилгээний нэгдсэн төв байгуулах, төрийн үйлчилгээний оператор бэлтгэх ажлын хүрээнд 2 албан хаагч сургалтанд хамрагдаж, тоног төхөөрөмжөө авчирч суурилуулаад, дотооддоо сургалт мэдээллээ хийх бэлтгэл хангаж байна.

- 2019 оны аймаг, сумын сайн малчид, алдарт уяачид, төрийн дээд шагналаар шагнагдах иргэдэд олгох ёстой байсан шагнал цар тахлын улмаас хойшлогдсон учир ойрын үед уг шагналуудыг сумын удирдлага гардууллаа.

- Аймгийн МХГ-ын Санхүүгийн аудитын А. Чулуунбатаар ахлуулсан ажлын хэсэг суманд 10 хоног ажиллаж, төрийн байгууллагуудын 2018, 2019 оны үйл ажиллагааны баримтанд шалгалт хийсэн.

Хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр: Сүхбаатар аймгийн Сонгуулийн хорооны ажлын хэсэг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр суманд ажиллаж сумын Сонгуулийн хорооны дарга, гишүүдэд сургалт зохион байгууллаа.

“Галба өөш Долоодойн сав газрын захиргаа”-наас амралт, аялал жуулчлалын чиглэлээр болон “Дарьганга сумын 100 жил” хөтөлбөрийн хүрээнд цахим сургалт хийж, зөвлөгөө зөвлөмж өгч хамтран ажиллалаа.

Эрүүл мэнд: Эрүүл мэндийн төвийн Нийгмийн ажилтан хариуцан 5 дугаар сард нийт амбулаториор үйлчлүүлэгч иргэдийн халууныг үзэж, 4 төрлийн 424 ширхэг гарын авлагыг 121 иргэнд өгч үйлчилсэн байна.

Байгаль орчин: Сумын Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас “ЗӨВ ДАДАЛ-НОГООН ИРЭЭДҮЙ” аяныг зохион байгуулсан ба тусгай хамгаалалттай газарт хог хаягдал, сэг зэмийг цэвэрлэх ажлыг зохион байгуулж 5-10 тн хогийг цэвэрлэсэн.

Хөдөө аж ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний чиглэлээр: Сумын засаг даргын орлогчоор ахлуулсан баг хөдөөгийн багуудад оготно устгалын ажлыг зохион байгуулж 5300 га талбайд 9835 кг огтоны хор цацлаа.

2 дугаар багийн 250 хуц ухнанд ангилалт хийсэн.

Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв: 05 дугаар сарын 15-наас эхлэн цаг агаарын аюултай үзэгдэл болохтой холбогдуулан малчин 185 өрхөд сургуулийн анги удирдсан багш нар өөрсдийн санаачилгаар мэдээг утсаар хүргэсэн.

“Хамгаалагдсан хүүхэд” аяны хүрээнд ЕБС нь цахим орчинд мэдээ мэдээлэл оруулж, эргүүл тандалтыг биечлэн хийж, “Маскаа зүүцгээе” аянд нэгдэн ажиллаж байна.

Мөнххаан:

Төрийн удирдлага зохион байгуулалтын чиглэлээр: Улсын Онцгой комиссын шийдвэрээр 05 дугаар сарын 31-нийг хүртэл улс орон даяар зохион байгуулагдаж буй “Маскаа зүүцгээе” аяныг сумын ЗДТГ-аас дэмжин ажиллаж байгаа бөгөөд төсөвт байгууллагуудын албан хаагчид худалдаа үйлчилгээний байгууллага, өрхийн болон нэгдсэн эмнэлэг, нийтийн гудамж талбай зэрэг олон хүн цуглардаг газруудаар явж 500 ш амны хаалтыг иргэдэд тараалаа.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын Онцгой комиссоос гаргасан уриалгыг дэмжиж сумын Алтан тээл баясгалант ХХК сумын Онцгой комисст 500,0 мян төгрөг хандивлалаа.

“Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Харилцаа Холбоо Мэдээлэл Технологийн газраас Төрийн үйлчилгээг операторын тогтолцоонд шилжүүлэх, тоон гарын үсэг нэвтрүүлэх, ажлыг эхлүүлэн операторын сургалтыг хийж 15,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийн дагуу “Сайхан бичигтэн” уралдааныг цахимаар зохион байгуулж шалгарууллаа.

2020 оны 1-р ээлжийн цэрэг татлагад тэнцсэн 44 цэргийн насны залуу нэгдсэн цэрэг татлагийн үзлэгт хамрагдаж, 23 цэргийн насны залуу эрүүл мэндээр тэнцэж ЦЖА-нд татагдсан.

ЗДТГ-аас багийн малчин өрхүүдээр явж суурь тойролт хийж хаваржилтын байдалтай танилцаж, төр захиргааны шийдвэрийг танилцуулах ажлыг зохион байгуулж иргэд, малчдаас ОНХСангийн санал авах, гал түймрээс урьдчилан сэргийлэх, мөн цар covid-19-ээс сэргийлэх анхан шатны зөвлөмж өгөх, төл бойжилттой танилцах зэрэг цаг үеийн мэдээ мэдээллийг хүргэж ажиллалаа.

Татвар : ХХОАТ-ын тухай хуулийн заалтын дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхээр хүсэлтээ ирүүлсэн 54 иргэдийн 19512255 мян төгрөгийн буцаан олголтыг олгоод байна.

Боловсрол: Цэцэрлэгийн 10 бүлгийн багш нар бүлэг бүрийнхээ группт үлгэрийн болон танин мэдэхүйн, шүлэг дуу цээжлэх чиглэлээр хүүхдэд зориулсан видео хийж оруулан, бүлгийн хүүхдүүддээ хүргэлээ. Уг группт эцэг эхэд зориулан багш, туслах багш нарын боловсруулж хийсэн 3 зөвлөмжийг байршуулж эцэг эх, иргэдэд хүргэлээ.

Цэцэрлэгийн хүүхдийн телевиз хичээлийн үзэлт, тайлагналт, хамтран ажилласан байдал 92.3% байна.

Соёлын төв: Номын сангийн олон нийтийн ажил 2 удаа, нийт уншлаганд 120 ном гарч 30 хүүхэд, 20 насанд хүрэгчдэд номоор явуулын үйлчилгээг хүргэн ажилласан.

Ном дахин засварлах ажил хийгдэж нийт 120 ширхэг номыг сэргээн засварлалаа.

Үндэсний бичиг үсгийн баярт зориулж Гэр номын сантай өрхийн цахим нэвтрүүлгийг хийж олон нийтэд сурталчиллаа. Мөн соёлын өв тээгчдийн цахим танилцуулгыг байршуулан ажиллалаа.

Эрүүл мэнд: “Амьсгалын замын өвчлөлийн үзлэг”-ийн өрөөг шинээр гаргаж тохижуулсан. Амьсгалын замын эмгэгтэй болон сүрьеэгээр өвчилж байсан хүмүүсийн өрхийн болон ойрын хавьтал, амьжиргааны түвшин доогуур 409 хүний судалгааг гаргаж ажилчдад мэдээлэл өгч тухайн хүмүүсээр сүрьеэгийн асуумж судалгааг авч, асуумж судалгаанд хамрагдсан хүмүүст “Даавуун макс хэрэглэх заавар” гарын авлага тараасан. Нийт 312 хүнд гарын авлага, мэдээлэл тараасан.

Хөдөлмөр эрхлэлт халамж, нийгмийн хамгааллын чиглэлээр: “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т Нийтийг хамарсан ажлаар 2 төсөл дэмжигдэн ирж 1, 2, 3, 4, 5-р багуудын нутагт Оготоно устгалын ажил хийгдэж нийт 53 иргэн 5 хоногт ажиллалаа. Мөн хог цэвэрлэгээний ажилд 10 иргэн ажиллаж байна.

- Бүлгийн зохион байгуулалттай хүнсний ногоо тариалах ажилд биргэн ажиллаж газраа хагалуулж, төмсний үрээ суулгаж эхлээд байна.
- Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт 2 иргэний тус бүр 5.0 сая төгрөгийн төсөл дэмжигдээд байна.

“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-т

- Ахмадын зөвлөх үйлчилгээ: 5-р багийн ахмад настан Ч.Цэндсүрэн Бүлгийн хүнсний ногоо тариалах бүлэгт зөвлөхөөр ажиллаж зөвлөгөө өгөн ажиллаж байна.
- Санхүүгийн дэмжлэг: 4-р багийн иргэн М.Ичинхорлоо- Хүнсний ногоо -2,0 сая, 5-р багийн иргэн Л.Өлзийт –Хүнсний ногоо -2,0 сая төгрөгөөр дэмжигдсэн.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар дэмжих хөтөлбөр”-т 5-р багийн иргэн Б.Дугаржав-Суран эдлэл -4,0 сая төгрөгөөр дэмжигдсэн.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан LMIS программд идэвхтэй ажил хайж 83 ажилгүй иргэн бүртгэлтэй байна. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сарын 21-нд хуралдуулж ХЭБҮ-нд хамрагдах 1 өрхийг хэлэлцэн дэмжиж шийдвэрлэлээ. Нийгмийн халамжийн сангийн олголт 328 иргэнд 39,614,730 сая төгрөгийн олголт хийсэн. Ортопед болон тусгай хэрэгсэл шаардлагатай Ахмад настан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Тэргэнцэр -1, Нурууны бүс -3, Алхуулагч-2 захиалгаар нийлүүлээ. Хүүхдийн мөнгөтэй холбоотой өргөдөл, гомдол 3 ирснийг ӨАТТ Судалгааг аван программд шивсэн.

COVID-2019 цар тахалын хүрээнд 3 Газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ 5 сараас 10 сар хүртэлх хугацаанд хүнсний талон авч буй иргэдийн мөнгөн дүн нэмэгдэж хүүхэд -16000, том хүн -32000 болсонтой холбогдуулан ХЭБҮ-гээ үзүүлдэг дэлгүүр болон ХЭБҮ-ээ авагч иргэдэд мэдээлэл өгч ажилласан.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Тэтгэвэрийн, тэтгэмжийн талаар болон шинээр хэрэгжиж байгаа малчин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэвэрийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, 3 хүртлэх насны хүүхдээ асарч байгаа эхийн сайн дурын даатгалын талаар нийт 120 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. Нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж 3 иргэн 1981.0 мянган төгрөг төвлөрсөн. 3 хүртлэх насны хүүхдээ асарч буй эх шинээр 10 гэрээ байгуулж 262.5 төгрөг төвлөрсөн. Өндөр настаны тэтгэвэр 8, тахир дутуугийн тэтгэвэр 1 тогтоогдсон. Мөн өндөр настаны тэтгэвэр тогтоолгохоор 8 хувийн хэргийн материал бүрдүүлж явуулсан болно. Эрүүл мэндийн даатгал 32 иргэн даатгуулж 1945.0 төгрөг төвлөрсөн. Сайн дурын даатгал шинээр 7 хүн гэрээ байгуулж даатгалд хамрагдсан бөгөөд нийт 3653.0 төгрөг төвлөрсөн байна.

Монгол бичгийн өдрийг угтан төрийн албан хаагчдын дунд цахим уралдаан зарлаж шалгарсан бүтээлүүдийг шагнаж урашууллаа.

ЗДТГазрын албан хаагчдын өрөөний хаягийг крилл болон Монгол бичгээр бичиж байрлууллаа.

ᠣ᠎ᠠᠭᠠᠨ ᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ, ᠠᠭᠤᠨᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ: Үлийн цагаан огтоно устгах, сумын төвийн хог хаягдлыг бууруулах төслүүдийг бичиж аймгийн ХХААГазар, ХХҮХэлтэст хүргүүлсэн бөгөөд хяналт шалгалтыг 2 удаа хийсэн.

1,3-р багийн 3-н булгийн эхийг хашиж хамгаалах ажил 100 хувь хийгдэж ажлын хэсэг хүлээн авлаа.

Сүхбаатар:

Төрийн удирдлагын чиглэлээр: Covid-19 шинэ корона вирус дэлхийн улс орнуудад тархсантай холбогдуулж ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалан ажиллаж байгаа сумын Онцгой комисст сумын ахмадын холбоо болон нийт ахмадууд 200 ширхэг маск, 146000 төгрөгний хандив, эмийн эргэлтийн сангаас 100 ширхэг маск, ариутгалын бодис тус тус хандивлалаа

Сумын Засаг даргын орлогч болон ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг 3, 4-р багт тус тус ажиллаж малчидтай уулзан ярилцаж тэдний санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ төр засгаас хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр сум орон нутгийн цаг үеийн ажил үйлчилгээг малчин иргэдийнхээ хотонд хүргэн ажиллалаа. Үүнд:

2020 оны хаврын ээлжит цэрэг татлагын урьдчилсан үзлэгт цэргийн насны 74 иргэн орохоос 46 хамрагдаж 16 залуу дараачийн шатны үзлэгт орохоор боллоо.

Эрүүл мэнд: Шинэ Корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Эрүүл мэндийн төвөөс албан байгууллага, аж ахуй нэгж, айл өрхүүдийн жорлон муу усны нүхэнд ариутгал халдваргүйжүүлэлт хийн мөн гэрийн нөхцөлд ариутгал халдваргүйжүүлэлтийг хэрхэн хийх талаархи зөвлөмж гарын авлагыг тараасан.

Байгаль орчин: 3 сарын 27-ноос 28-нд шилжих шөнө тус сумын 1-р баг, Эрдэнэцагаан сумын 6-р багийн зааг нутагт хууль бусаар ашигт малтмалын олборлолт хийж байсан үйлдлийг сум, аймгийн Цагдаагийн газартай хамтран таслан зогсоож тухайн газар нутгийг зургаан хүний бүрэлдэхүүнтэй баг хамгаалалтад аваад байсан ч 04 дүгээр сарын 02-ноос 03-нд шилжих шөнө улсын дугааргүй, 8-9 тээврийн хэрэгсэлтэй 20 гаруй иргэн тус газар руу хүч түрэн дайрч, мөн зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлож эхэлсэн ба энэ талаар дахин дуудлага ирсний дагуу хоёр шуурхай бүлэг очин зогсоож, тухайн иргэдийг саатуулсан. Одоогоор аймгийн Цагдаагийн газарт 7 бүлгийн, 7 тээврийн хэрэгсэлтэй, 29 иргэнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу тус газарт 2 сум ээлжлэн хамгаалалтанд гарч ажиллаж байна.

2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Дорнод аймгийн Матад сумын нутаг “Цар” гэдэг газраас гарсан хээрийн түймэр тус сумын 1-р багийн нутаг “Дөрвөлжин худгийн тал” гэх газарт орж ирсэн бөгөөд түймэр унтраах 7 хүний бүрэлдэхүүнтэй 1 дүгээр ээлжийг шуурхай томилон ажиллуулсан. Түймэрт 3200 га талбай болон 2 айлын өвөлжөө шатсан ба нийт 24,697,200 төгрөгийн зардал гарсан байна. Түймрийн эзэн холбогдогчийг тогтоож хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авахаар ажиллаж байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны хүрээнд нийтийг хамарсан ажил зохион байгуулж 10 иргэнээр нийтийн эзэмшлийн зам талбай, гуу жалганы хогыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сүхбаатар:

Төрийн удирдлага: Аймгийн Засаг даргын 2020 оны А/314 дүгээр захирамжийн дагуу 05 дугаар сарын 02-04-ний өдрүүдэд авто, тээврийн хэрэгслийн "техникийн хяналтын үзлэг" явагдсан.

Хөдөө аж ахуйн чиглэлээр: Энэ онд улсын сайн малчин-1, аймгийн сайн малчин-3, аймгийн мөнгөн унаганы эзэн-1, алтан төлийн эзэн-1, сумын сайн малчин-15, мянгат малчин-19, сумын алдарт уяач-5 тус тус тодорсон бөгөөд малчдын шагналыг энэ сард ЗДТГ-аас томилогдсон ажлын хэсгүүд малчдын гэрт нь очиж гардуулах ажлыг зохион байгуулсан.

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 5-р сарын 20-23-ны өдрүүдэд 1-р багт, ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг 5-р багт тус тус ажиллаж малчид, хөдөлмөрчидтэй уулзан ярилцаж тэдний санал хүсэлтийг сонсохын зэрэгцээ төр засгаас

хэрэгжүүлж байгаа бодлого, шийдвэр сум орон нутгийн цаг үеийн ажил үйлчилгээг малчин иргэдийнхээ хотонд хүргэн ажиллалаа. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх ажлын санал авах
2. Мал төллөлтийн мэдээг өрх нэг бүрээр авах
3. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх анхаарал санамж хүргэж, гарын үсгийн баталгаа авах
4. Корона вирусын талаар мэдээлэл хүргэх
5. МУ-ын ерөнийлөгчийн БНХАУ-д бэлэглэсэн 30000 хонинд хандив цуглуулах
6. Эрүүл мэндийн үзлэг
7. Бусад цаг үеийн асуудлаар мэдээ, мэдээлэл хүргэх

Аймгийн засаг даргын А/334 дүгээр захирамжийн дагуу сумын Засаг даргын А/85 дугаар захирамж гарч хагас жилийн мал тооллого 2020,05,25-05,31 ны хооронд зохион байгуулагдаж байна. Түүвэр судалгаанд 139 өрх хамрагдахаар сонгогдож ирсэн. Мал тооллогын комисс 17 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Түвшинширээ:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар БНХАУ-д туслах аяныг малчид дэмжиж, хонь хандивлах ажил үргэлжилж байна. Одоогоор 200 гаруй хонь хандивлаад байна.

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан сумын шилдэг гэр бүлүүдийг тодруулан нийгэмд үлгэр дууриал болгох, алдаршуулах арга хэмжээг олон нийтийн сүлжээг ашиглан зохион байгуулж ажилласан байна. Мөн Улс, аймгийн сайн малчидыг шалгаруулан зохиох шалнал, урамшуулал хүндэтгэлийг үзүүлсэн байна.

Хүн ам зүйн чиглэлээр: ҮСХ-ноос Дэлхийн банкны санаачлагаар Коронавирусийн өрхөд үзүүлж буй нөлөөллийг судлах зорилгоор УТСАНД СУУРИЛСАН СУДАЛГААГ 2018 оны ӨНЭЗС-нд хамрагдсан өрхүүдийн дунд 2020 оны 5-р сарын 18-наас 5-р сарын 30, 8-р сарын 10-наас 8-р сарын 20 хооронд 2 үе шаттайгаар 2000 өрхийг хамруулж зохион байгуулахаар болсон. Уг ажилтай холбоотой түүврээр сонгогдсон 5 өрхийн утасны жагсаалтыг тулгаж, шинэчлэн аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлээд байна.

Гэр бүл, хүүхдийн чиглэлээр: Сумын ЗДТГазар, багийн ажлын албанаас Дэлхийн гэр бүлийн өдрөөр сумын шилдэг тэргүүний гэр бүлүүдийг “Шилдэг бүтээлч гэр бүл”, “Оюунлаг гэр бүл”, “Хүмүүнлэг гэр бүл” гэсэн 3 номинацийн дагуу шалгарууллаа. Гэр бүлийн үнэ цэнээ эрхэмлэн олон нийтэд нэр хүндтэй, үлгэр дуурайлалтай амьдарч байгаа, гэр бүлүүдийг шалгаруулан алдаршуулах зорилготой шилдэг гэр бүл шалгаруулах удирдамж, шилдэг гэр бүл шалгаруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулан Засаг даргаар батлуулж, Түвшинширээ цахим хуудсаар болон багийн Засаг дарга нараар иргэдэд мэдээллийг хүргэлээ. Шилдэг гэр бүлийн материалуудыг багийн Засаг дарга нараар дамжуулан бүрдүүлүүлж, нийт 8 гэр бүл нэр дэвшсэнээс 3 номинаци тус бүрд 1 гэр бүлийг шалгарууллаа.

Хөдөө аж ахуй: Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг аймгийн мал эмнэлгийн газраас татан авч, сумын засаг даргын А/23 дугаар захирамжаар сумын бүх үхэр сүрэгт вакцинжуулалт хийх тарилгын 5 ажлын хэсэг гарч ажиллалаа.

Мөн сумын хэмжээнд хийгдэх шимэгчтэх өвчнөөс урьдчилан арга хэмжээг мал эмнэлгийн нэгдсэн системд шивж оруулж төлөвлөгөө 80 хувьтай шивэгдсэн байна.

Мерси кор ОУБ-ын LTS-3 төслийн хүрээнд Хэнтий аймагт зохион байгуулагдсан малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт, судалгаа, мэдээлэл цуглуулах сургалтад Тархвар зүйч Б. Оюун-Эрдэнэ хамрагдаж, практик дадлагыг 4 багийн 60 өрхөд хийлээ.

Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаач, багийн засаг дарга нартай хамтран сумын нутагт тархсан үлийн цагаан оготны судлалгааг гаргаж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10000 га талбайд үлийн цагаан оготной тэмцэх ажлын гэрээг байгуулаад байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зарлагдсан төсөл хөтөлбөрүүд болох "Ажлын байрыг дэмжих", ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдэд сумын хэмжээнд нийт 5 иргэний төсөл өгсөнөөс 4 иргэний төсөл дэмжигдсэн. Төсөл нь дэмжигдсэн иргэдтэй "Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн гэрээ", "Эргэн төлөлтийн хуваарь", ""Зардлын төсвийн тооцоо", Батлан даалтын гэрээ"

зэргийг байгуулж, нийт 23,5 сая төгрөгийн санхүүжилтийг авахаар баримт бичгийг аймгийн ХХҮГ-т хүргүүлээ.

"Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн нийтийг хамарсан ажлыг зохион байгуулахад аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон сумын Засаг даргын тамгын газар хамтран "Сэг зэм", "Ногоон байгууламж" төслийг 2020 оны 04-р сарын 13-наас 2020 оны 05-р сарын 08-ны хугацаанд хамтран хийж гүйцэтгэх, давхардсан тоогоор ажилгүй 20 иргэнийг түр ажлын байраар хангаж ажиллалаа. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах гэрээг сумын Засаг даргаар батлуулж, төсөлд ажиллах 10 иргэнтэй гэрээ байгуулж, нийт 4,989,600 төгрөгийн цалин олгуулсан байна.

ХЭДС-аас 2018-2019 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн эргэн төлөлт хийгээгүй иргэдтэй уулзаж цаг хугацаандаа хийхийг шаардан хийлгэж байна. 5-р сарын байдлаар 2018-2019 оны малжуулах төсөлд хамрагдсан 5 өрх хуваарийн дагуу 5,750,000 төгрөгийг бүрэн хийлгэсэн.

Хүнсний эрхийн бичиг үйлчилгээнд хамрагдаж буй 33 өрхөд 151 иргэнд 2020 оны 5-р сарын хүнсний эрхийн бичгийг нэмэгдүүлсэн үнээр олгох "Худалдан авах бүтээгдэхүүн"-ний жагсаалтыг бэлтгэн өгч олгож эхэлсэн.

Нийгмийн даатгал: 1995-2000 оныг нэг нөхөн шимтгэл төлөх журмын дагуу иргэдэд зөвлөгөө өгч байна. 21 хүний материалыг бүрдүүлж аймгийн НДХ-т хүргүүлсэн. COVID 19 буюу цар тахлын үед авах арга хэмжээний дагуу НДШимтгэлээс чөлөөлөлтөнд 16 ААНэгж хамрагдсан.

Түмэнцогт:

Төрийн удирдлагын чиглэлээр: Засаг даргын А/43 дугаар захирамжаар "Үндэсний бичгээ дээдэлэе" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилж төлөвлөсөн ажлуудыг зохион байгуулсан ба төсвийн байгууллагын албан хаагчдыг бүрэн хамрууллаа.

"Covid-19" шинэ төрлийн вирустэй холбогдуулан ААНэгж, байгууллага, ТББ, иргэн хамтран Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмж, чиглэл, зааврыг тухай бүр сурталчилан, онлайн мэдээ, мэдээллүүдийг түгээж байна. Энэ хүрээнд нийт 6021 ширхэг гарын авлага тарааж, Цахимаар 250 төрлийн мэдээлэл хийсэн байна.

Хөдөө аж ахуй: Хагас жилийн малын түүвэр судалгаанд 76 өрх хамрагдан тооллогын хийж явцын мэдээг 2 хоног тутам мэдээлэн ажиллаж байна.

Байгаль орчин: Сүхбаатар аймгийн БОАЖГазрын 2 сая төгрөгийн санхүүжилтээр Нэгдсэн хогийн цэгийн 2 га газрыг түрж цэгцлэн, үхсэн малын сэг зэм хаях цэг байгуулж, хаягжуулах ажлыг зохион байгуулж, иргэдийг хогоо зориулалтын цэгт хаяж хэвшихийг уриалан ажиллаж байна.

Уул уурхайн ААНэгжүүдтэй нутгийн захиргааны байгууллага "Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах" гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд хөдөөгийн 1, 2 дугаар багийн нутаг дэвсгэрт хаягдсан үхсэн малын сэг зэм - бод 240, бог -353 цуглуулж булж устгах ажлыг уул уурхайн компаниудтай хамтран зохион байгуулсан.

Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан ААНэгж байгууллага 5, өрх 93, Ой төгөл 5 га газарт нийт 3960 модыг 5.735.000 төгрөгийн санхүүжилтээр тарьсан.

Мал эмнэлэг: Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын вакцинжуулалт хийх тухай сумын Засаг даргын А/45 дугаар захирамжаар вакцинжуулалт ажлыг зохион байгуулж, нийт малын 74 хувийг вакцинд хамруулаад байна.

Нийгмийн даатгал, Хөдөлмөр, халамж : Нийгмийн даатгалын хуулийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг тэтгэвэр тогтоолгох 49 иргэнд зөвөлгөө өгч тэтгэврийн материалыг бүрдүүлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгогдох төсөл хөтөлбөр зарлагдсантай холбоотой ХХҮГазарт 13 төсөл хүргүүлсэн.

Боловсрол: ЕБС-ийн 33 суралцагч ЭЕШ өгөх ба 12-р ангид хичээл заадаг 12 багш сурагчдад давтлага өгч байна.

Багш, ажилчид, сурагч, эцэг эх, иргэдэд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн дэглэмийг сахих талаар болон ЭЕШ-ын давтлага, теле хичээлийн талаар мэдээлэл, сурталчилгааг сургуулийн албан ёсны цахим хаягаар байнга өгч, хариу мэдээлэл авч ажиллаж байна. ЕБС-аас 78 төрлийн мэдээллийг цахимаар нийтлэхэд

давхардсан тоогоор 969 эцэг эх, 711 багш, 255 сурагч, 113 ажилтанд мэдээлэл хүрсэн байна.

Уулбаян:

Төсөв санхүү: Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр 6 иргэнд 34500,0 мянган төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн.

Нийтийн эзэмшлийн 24 айлын орон сууцны дээврийн засварын ажлын тендерт шалгарсан “ЛХАТОНОМ” ХХК-тай гэрээ байгуулж, засварын ажлыг эхлүүлээд байна.

2020 оны ОНХСангийн санал асуулгыг уламжлалт аргаар болон цахимаар санал авч 100 орчим иргэн цахимаар саналаа өгөөд байна.

Хөдөө аж ахуй: Бух , бог малын хээлтүүлэгчийн тоогоор ээмэгний захиалга бух 113, хуц 1035, ухна 514 бүгд1662 хээлтүүлэгчээс бух 8, хуц 50, ухна 24 нийт 82 ээмэгний захиалга өгөөд байна.

Сумын хэмжээнд 8000 га талбайд оготно устгал хийхээр 11776,0 мянган төгрөгийн гэрээг ХХААГазартай байгуулсан. Үүнийг ажлын хэсэг хуралдаад Тэгш багийн Цагаан чулуут, Баян далай гэх газарт хийхээр шийдвэрлэсэн. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт: Хөдөлмөр эрхлэлтийн 5 сарын шинэ ажлын байрны мэдээ -12 болон түр ажилд зуучлагдсан 13 иргэний мэдээллийг 25-ны өдрийн байдлаар Хөдөлмөрийн зах зээлийн LMIS программд шивж баталгаажууллаа. Ажил хайгч иргэнээр бүртгэгдсэн 83 гаруй иргэнээс 20 иргэний мэдээллийг шинэчлэхэд эмэгтэй-12, шинээр 10 иргэнийг ажил хайгчаар бүртгэхэд эмэгтэй-10 бүртгэгдлээ. Шинэ ажлын байранд-12 эмэгтэй-6, түр ажлын байранд-13 эмэгтэй-8 иргэн зуучлагдсан. Нийтийг хамарсан ажил, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл, Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт-2, өмнөх онд авсан төслийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлж байна.

Боловсрол: Цахим сүлжээнд эрүүл мэндийн болон теле хичээлээ үзэх талаар нийт 321 зөвлөгөө зөвлөмжийг боловсруулан сумын болон сургуулийн нээлттэй группд байршуулсан. Мөн теле хичээл үзэх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор 11 хүүхэд цахим сүлжээнд уриалга оруулсан. Сурагчдын теле хичээл үзэх идэвх оролцоо 70 хувьтай байна.

Багш нар өөрсдөө нийт 9 цахим хичээл бэлтгэн сум, сургуулийн нээлттэй группэд байршуулсанаар сурагчид багшийнхаа бэлтгэсэн хичээлийг илүү сонирхон үзсэн байна.

Хорио цээрийн дэглэмтэй энэ үед “Бид унших дуртай” групп дээр 19 үлгэр, шүлэг яруу найраг, зохиолуудыг байршуулав.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 75 хүүхдийн дотуур байрын барилгын гүйцэтгэл 80 хувьтай байна.

Хүүхдийн цэцэрлэг: “Цэгээр наадъя” дэвтэрийн аймгийн хэмжээний шалгаруулалтанд 18 дэвтэр хүргүүлж, 4 хүүхэд бүтээлч хүүхэд, 3 гэр бүл бүтээлч гэр бүл, нэг багш онцлох багшаар шалгарлаа.

Бүлгийн багш нар номын богц аялуулж 62 хүүхдийг хамрууллаа.

Соёлын төв: Нийтийн номын сан групп хаягаар “Цахим уншлагад нэгдэцгээе” аян зохион байгуулж зохиол бүтээл байршуулж иргэдэд цахим үйлчилгээ үзүүлж байна. Мөн Уулбаян Соёлын төв цахим хаягт “Нийтийн бүжиг” бусад мэдээлэл сурталчилгааг байршуулаад байна.

Эрүүл мэнд: Урьдчилан сэргийлэх үзлэг-215, идэвхтэй хяналт-57, дуудлагаар гэрийн үзлэг-62, гэрийн идэвхтэй үзлэг-72, алсын дуудлага-48, жинлэсэн хүүхдийн тоо-21, артерийн гипертензи-117, хөх-145, эсийн шинжилгээнд-45 хамрагдаж нийт 1015 үзлэг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

Халзан:

Засаг даргын Тамгын газар: Хагас жилийн мал тооллого явуулах сумын Засаг даргын А/52 дугаар захирамжаар тооллогыг явуулах сумын комисс,багийн ажлын хэсгийг байгуулсан.Хагас жилийн мал тооллогын түүвэрт 66 өрх сонгогдсон.

Сум хөгжүүлэх сангаас зээл олгох төсөл сонгон шалгаруулах зөвлөл хуралдаж 11 иргэнд 54,5 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна.Энэ сард 3 иргэнд 20,0 сая төгрөгийн зээлийг олгоод байна.

Төсөв санхүү: Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 47200,0 мянган төг авч, сумын татварын орлогоор 1162,6 мянган төгрөг орсон.

ОНХС-ийн орлогын шилжүүлгээр 3831,0 мян/төг санхүүжилт ирсэн байна. Энэ сард 1-р багийн их засварын ажлаар УБ хотын "И.Пи.Эс" ХХК тендерт шалгарч 19898,5 мянган төгрөгөөр ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

ЕБС: Теле хичээлийн үзэлтэд тандалт судалгаа хийх зорилгоор сургалтын менежер, сургуулийн захирал нар анги бүлгийн группүүдээр зочлон явцыг харахад ангиудын 9 буюу 90% нь дотоод групптэй байна.

БСУГ-аас сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарын дунд зохион явуулсан "Олон нийтийн оролцоонд тулгуурлан байгууллага хөгжүүлэх арга зүй" сэдэвт илтгэлийн уралдааны 1-р шатанд захирал С.Эрдэнэтуяагийн илтгэл шалгарч, 2-р шатанд орохоор бэлтгэлийг ханган ажиллаж байна.

Улсын онцгой комисс, Аймгийн засаг даргын албан даалгаврын дагуу "Маскаа зүүцгээе" аяныг өрнүүлсэн ба 60ш зөвлөмж, 50ш маскыг сумын ард иргэдэд тараасан.

Шинээр 1-р ангид элсэн суралцах болон теле хичээл огт үзэж чадахгүй байгаа сурагчдаар сургуулийн удирдлагууд болон 1-р анги авах багш нар гэрийн эргэлт хийж, хүүхдээ тойргийн сургуульд хамруулах талаар зөвлөгөө зөвлөмж, 1-р ангийн сурагчдад урилга өгсөн.

Эрүүл мэндийн төв: ЭМТ нь 2020 оны 05 сард Эрүүл мэндийн даатгалын сангаас 39 иргэний 1264870 төгрөгний тусламж үйлчилгээг үзүүлсэн.

ЭМС-ын 2020 оны 02 сарын 20 А\126 маягтын дагуу хариуцлагатай жижүүрийн мэдээг 2020 оны 05 сарын 31 хүртэл өгч ажиллаж байна.

Маскаа зүүх аяны хүрээнд 200 ш маск оёж зорилтод бүлгийн иргэдэд тарааж өгөв.

Хөдөө аж ахуй: Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой энгийн механик аргаар тэмцэх ажлын хүрээнд Улаанбатар хотод захиалгаар стандартын дагуу 60 суултуур, 5 үүр хийлгэлээ

Байгаль орчин: Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас "Зөв дадал- Ногоон ирээдүй" байгаль хамгаалах сарын аяныг 5 дугаар сарын 1- ээс 6 дугаар сарын 1-ний хооронд зарлан орон даяар зохион байгуулж байгаата холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулж нийт төсвийн байгууллагын 87 хүн хамрагдаж 10,5 га газраас 10 тонн хогийг цэвэрлэн нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэв.

Байгаль орчны газар, сумын засаг даргын гэрээнд тусгагдсаны дагуу сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг цэгцлэх ажлыг хувь иргэнтэй гэрээ байгуулан эхлүүлээд байна. Энэ ажил 35% -тай явагдаж байна.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдрөөр 3 төрлийн 130 ширхэг модны суулгацыг нөхөн сэргээлтээр суулгаж услах ажлыг зохион байгуулав.

Эрдэнэцагаан:

"Монгол үндэсний бичиг соёлын баяр", "Цэвэр орчин", ЗДТГ "ЭКО хамт олон", "Угийн бичиг" зэрэг аян зохион байгуулж холбогдох дээд байгууллагуудад хугацаанд нь биелэлтийг хүргүүллээ.

Төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэл ажлыг хангах хүрээнд ТАХ-дын монгол бичгийн мэдлэгийн түвшинг тогтоох, мэдлэгийн цар хүрээг нэмэгдүүлэх Цаашид иргэд олон нийтэд үндэсний бичиг соёлоо сурталчилах сургах ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Үндэсний бичгээ дээдлэгч" хамт олон болох ажлын хүрээнд ЗДТГ-аас Соёлын төвтэй хамтран удирдамж, хөтөлбөр гарган батлуулж ажилтан, албан хаагчдын дунд "**Үндэсний бичгээ үлгэрлэн хөгжүүлэе**", "**Угийн бичиг-Удмын бахархал**" уриатай 1 өдрийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаа нь "Сайхан бичигтэн", "Хурдан уншигч", "Үндэсний номын өргөө", "Гарын үсгээ монгол бичгээр зурж сурцгаая", "Угийн бичиг-Удмын бахархал" төрлүүдээр явагдаж ЗДТГ-аас 23 ажилтан, албан хаагч хамрагдаж амжилттай оролцлоо.

Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн тасаг 24.9 сая төгрөгийн өртөг бүхий 2 ш автомашинаар хангагдлаа.

Мөн хог зөөврийн машиныг 32.5 сая төгрөгөөр нийлүүлсэнийг хүлээн авч ашиглаж эхлээд байна.

Сумын төв зам дагуух гэрэлтүүлэгийг сайжируулах ажлын хүрээнд 74 ш гэрлийг суурилуулан, 22.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Уг ажлын гүйцэтгэл ажлын гүйцэтгэл 70% байна.

Морины хөшөөний тохижилтын ажлыг хүлээн авч 15.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан.

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн талаар 7 иргэнд мэдэгдэл өгч ажилласны үр дүнд 12.6 сая ₮ төвлөрүүлсэн.

Боловсрол:

Хүүхдийн 1-р цэцэрлэг: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Яамнаас 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 1 дүгээр ангид элсэн орох хүүхдийн эцэг эхэд зориулан "Та хүүхэддээ сургуульд орохын өмнө хэрхэн туслах вэ?" гарын авлагыг эцэг эхээр дамжуулан хүүхэд багачуудад хүргэж байна.

Багш нар хөдөлгөөнт эргүүлийг өдөр бүр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд Амны хаалтыг зөв сонгон зөв хэрэглэх, Хүүхдийн аюулгүй орчин, COVID.19 virus.c хэрхэн сэргийлэх талаар нийт 60ш зөвлөмжийг ард иргэддээ тараан, давхар аман зөвлөгөөг өгч ажиллалаа.

Хүүхдийн 2-р цэцэрлэг: Байгууллагын 1 албан хаагч 4 блок аяныг өрнүүлж цэцэрлэгийн угтах хаалгыг шинээр хийж тус хаалган дээр монгол бичгээр хаяг бичүүлээ. COVID-19 халдвараас сэргийлэх арга хэмжээг авч багш ажилтан бүр 5 маск оёж зорилтод бүлгийн 20 иргэн, хилийн цэргийн 80 алба хаагчдад хандивлалаа.

Ерөнхий боловсролын сургууль: Үндэсний бичиг соёлын өдөрийг тохиолдуулан байгууллагын сайхан бичигтэн уралдааныг зохион байгуулсан. Нийт хүүхэд 143, насанд хүрэгчдийн 15 бүтээл ирсэн. Үүнээс эхний 10 сайхан бичигтэнг шалгаруулсан.

Багш ажилчид нээлттэй 4 групп болон, 43 бүлгийн дотоод группээр "ковид-19" өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмжийг /120 ширхэг брошур хийж тараасан./ тогтмол хүргэн ажиллаж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтын танхимын сургалтанд төгсөх ангийн /12-р анги/ хүүхдүүд бүрэн хамрагдаж байна. Сурагчид давтлагын хуваарийн дагуу ирж давтлагандаа сууж байна. Давтлаганд ирж буй сурагчдын халууныг үзэж, гарыг ариутгаж, мөн явах үед нь халууныг нь үзэж бүртгэл хөтлөн хяналт тавин ажиллаж байна. ЭЕШ өгөх сурагчдыг 7 хичээлийн цахим сорилгод хамруулсан.

Сумын төвд- 644, хөдөө- 637, бусад аймаг хот- 78 сурагч теле хичээлээ үзэж байна. Нийт 1359 сурагчаас 1021 сурагч буюу 75.1 хувьтай теле хичээлээ үзсэн байна. Үүнээс бага ангийн 509 буюу 74.6 хувьтай, дунд анги 338 сурагч буюу 72.8 хувьтай, Ахлах анги 174 сурагч буюу 81.3 хувьтай теле хичээлээ үзсэн байна.

Соёл урлаг. Жил бүрийн 5-р сарын эхний 7 хоногийг бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүлдэг ажлын хүрээнд Соёлын төв нь музейн өдөртэй хамтатган тусгай хөтөлбөр удирдамж гарган зохион байгуулсан. Монголчуудын бичиг үсгийн дурсгал номын үзэсгэлэн, "Бидний бахархал хүмүүн бичиг минь" шүлгийн уралдаан, ТАХ-дын дунд Хурдан уншигч шалгаруулж "Монгол бичиг"-ийн мэдлэгийн түвшин тогтоох, "Цэвэр сайхан бичигтэн", "Уран бичигтэн" шалгаруулах, "Хутагтын түүхэн замнал" эссэ бичлэгийн уралдаан, Дэлхийн музейн өдрөөр Хутагтын музейг сурталчилах, танилцуулах, ТСДГ-ыг цувралаар ард иргэдэд хүргэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

"Хутагтын түүхэн замнал" эссэ бичлэгийн уралдаан, цэвэр сайхан бичигтэн, байнгын уншигч нарын сонирхолтой ярилцлага зэрэг тэмцээнүүдийг зохион байгууллаа. Цахим сүлжээнд тавьсан мэдээллийн тоо өөрийн хаягт- 48, бусад хаягт -26 тавьж байршуулж ард иргэдэд хүргэн ажиллалаа.

Соёлын өвийн чиглэлээр: 7-р багийн нутаг дэвсгэр Хавх толгой, 1-р багийн нутаг Лхачинвандад уул, Араат 4-р багийн нутаг Зотол хаан уул гэх маршрутаар шинээр илэрсэн хөшөө дурсгал, булш, хиргэсүүр болох 80ш дурсгалыг бүртгэн баримтжуулж ажиллалаа. Сумын түүх соёл, хөшөө дурсгалыг цахим хэлбэрээр цувралаар ард иргэдэд танилцуулан ажиллаж байна. Сум орон нутагтай холбоотой 18 ширхэг мэдээ мэдээллийг хүргэн, дагаж хандсан хүний тоо 10,000 гаруй болсон байна.

Номын сангийн ажлын хүрээнд: Цахимаар байнгын үйлчлүүлэгч нарын тухай номтой нөхөрлөсөн сонирхолтой бичлэгүүдийг цувралаар хүргэж байна. Энэ сард номын сангаар 60 хүн үйлчлүүлсэн ба гэрээр 17 ном уншлаганд гарсан.

Эрүүл мэндийн төв: Хүн амд урьдчилан сэргийлэх болон идэвхитэй хяналтын үзлэгийг эмч нарын үзлэгийн хуваарийн дагуу нийт 1198 хүнд үзлэг хийснээс ,359 урьдчилан сэргийлэх үзлэгт , идэвхитэй хяналтаар 205, стационараар нийт 43 хүнийг хэвтүүлэн эмчлүүлээд байна.

Эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 266 эмэгтэй хамрагдаж үзлэгийн хувь 15,5% байна. Нийт 96 өвчлөл илэрсэнээс 79-г эмчлэн эрүүлжүүлж, эрүүлжилтийн хувь 82,2% байна.

Сумын нөхөн үржихүйн насны 1720 эмэгтэйн бүртгэл судалгааг шинэчлэн баяжилт хийж , түүнээс өртөмтгий бүлгийн 675 эмэгтэйн судалгааг гаргаж, бүлэг тус бүрээр нь ангилан жирэмслэхээс сэргийлэх аргыг сонгон хэрэглүүлэв.

Сэргээн засах эмчилгээгээр нийт 42 хүн эмчлүүлсэн. 2020 оны 5-р сарын байдлаар нийт124 хүнийг халдварт өвчнөөс сэргийлэх вакцинд хамруулсан.

Дархлаажуулалтын сургалтад 104 хүн, Эхийн сүү эрүүл өсөхийн эхлэл, сургалтыг зохион байгуулж 204ш гарын авлага тараасан. Энхрий үрс эрүүл торниход эцэг хүний оролцоо” сэдвээр 10 ээжид сургалт зохион байгуулж, 5 төрлийн 50ш гарын авлага түгээлээ.

Нийт 115 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, СЗЭ-гээр 20 хүүхдийг эрүүлжүүллээ.

Сувилахуйн тусламж үйлчилгээг давхардсан тоогоор 2795 хүнд үзүүлсэн байна. Үүнээс: Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 350, өдрийн эмчилгээнд 10 хүн, амбулаторын тусламж үйлчилгээ 287, гэрийн эргэлт 26 хүнд тус тус үзүүлсэн.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл мэндийн төвийн Ёс зүйн багаас “Амны хаалтаа тогтол зүүх”, 2 метр зай барих талаар тус тус Уриалга гарган цахим сүлжээгээр түгээсэн. ГТУА-47-р ангийн 23 албан хаагчдад Хамгаалах хувцас өмсөх, тайлах сургалтыг зохион байгууллаа.

Коронавирусээс урьдчилан сэргийлэх айл өрхөд өгөх зөвлөмж, давсны хэрэглээг багасгах талаарх зөвлөмжүүдийг эмч, эмнэлгийн ажилчид олшруулан хувиарлан авч нийт 200 айлын хашааны хаалган дээр наасан.

ЭМТ-ийн дарга, НЭМА, ахлах сувилагч нар 16 айлын 28 хүнд 5 төрлийн /гал түймрээс урьдчилан сэргийлэх, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, коронавирүсээс урьдчилан сэргийлэх, ариутгал, халдваргүйтгэл хийх зааварчилгаа / 112 зөвлөмж, гарын авлага 56 маскын хамт өгч, 5 өндөр настан, 3 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийн ажиллалаа

Коронавирүс /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж наадаг цаасан дээр бэлтгэн сумын талхны 3 цехүүд, 10 хүнсний дэлгүүрүүдэд нийт 550 ширхэгийг өгч байршуулан ажиллалаа.

Хот, аймаг, сум хоорондын тээврийн жолооч нарт 3 төрлийн зөвлөмж өгч, маскаа тогтмол зүүж хэвших талаар зөвлөгөө мэдээлэл өгөн ажиллалаа.

Байгаль орчин: 6-р багийн нутаг болох “Төмстэйн сэрвэн” гэх газар хууль бусаар ашигт малтмал эрж хайж байсныг хамгаалалтанд авч 14 хоног эргүүл хяналтын ажлыг хийсэн байна.

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн 120 тн хогийг түрж цэгцэлсэн. Төрийн болон ТББ-ын нийт 450 ажилчин албан хаагчид, 8-н багийн иргэдийн Төлөөлөл хамтран Сумын төв дотор болон төвөөс гадна 4-5 км-ын радиуст нийтийн их цэвэрлэгээг хийж 130 тн хогийг зөөвөрлөж устгаж ажиллалаа.

Ерөнхийлөгчийн зарлигаар Эко орчин бүрдүүлэх зорилгоор Тамгын газрын даргын тушаалын дагуу бүх нийтээрээ мод тарих ажлын хүрээнд 200 ширхэг улиас мод тарьсан байна. Төсөвт байгууллагууд айл өрхүүд 100 ш модны суулгац, 30 монос, 120 м.кв талбайд зүлэгжүүлэлт, Тамгын газрын эко аяны хүрээнд байгууллагынхаа хашаанд цэцгийн мандал цэцэг тарьж, согооворын үр суулгаж, зүлэгжүүлэх талбайд цэцэгийн үр, огурци, манжин, лууван, помидор тарьсан.

Хөдөө аж ахуй: Тус сумын Сүүл сэрвэн гэдэг газарт нохойнд галзуу өвчний шинж тэмдэг илэрсэн ба дээж матераилыг АМЭЛ-т хүргүүлж шинжлүүлэхэд, 20-465 тоот шинжилгээний дүгнэлтээр галзуу өвчин болох тогтоогдож тухайн хотонд хязгаарлалтын дэглэмийг тогтоон заавар зөвлөмжийг өгч ажилласан. 14 хоногийн дараа малд эрүүл

мэндийн үзлэгийг давтан хийж хот айлын хашаа хороонд ариутгал халдваргүйтгэлийг хийж хязгаарлалтыг цуцалсан.

1-р баг Түгээмэл хэмээх газар Өнөрбатын суурьт 20-31 тоот шинжилгээний дүгнэлтээр “Колибактериоз” өвчин болох тогтоогдсон. Тухайн хот айлыг 10км-ын радиустай Сумын Засаг даргын 2020 оны 04 сарын 14-ны өдрийн А/64 тоот захирамжийн дагуу хязгаарлалтын дэглэм тогтоосон.

“Хадын булан” ХХК “Их булан” хэмээх Б.Баасандоржийн суурьт малын халдварт галзуу өвчний шинж тэмдэгтэй дуудлага ирсэнийг, тухайн багийн малын эмч Ш.Түвшин дээж материалыг аргазүйн дагуу авч МЭЛ-т оношийг баталгаажуулахаар дээж хүргүүлэх дагавар, тархварүйн хуудсыг бөглөн хүргүүлж ажилласан. Мөн тухайн хот айлд ойролцоох өрхүүдэд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх /7100/ м/тунг хот айлуудын нхонь, ямаа үхэрт хийсэн. Дээж материалаыг УМЭАЦТЛ-т хүргүүлж Галзуу өвчин болох тогтоогдож хязгаарлалтын дэглэмийг 14 хоногийн хугацаанд хийсэн.

Сумын хэмжээнд Гэр хорооллын жорлон муу усны нүх 255ширхэг 7000м², нийтийн эзэмшил 10ш 13000м², малын хашаа хороо 25 өрхийн 35 ширхэг хашаа 30000м², худаг уст цэг 15ш 4500м², устгасан хүүр сэг зэм 117 ширхэг 5500 м² ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

ДХХ, Цусан халдварт, шөвөг ярын вакцинжуулалтыг 2020 оны захиалгын дагуу 6 ААН-үүдэд хуваарилан олгож, вакцинжуулалтын явц нь 65,7% -тай явж байна. Тухайн тарилга хийж байгаа хот айлын хашаа хороонд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэж байна. Хөдөө багуудын айл өрхөөр хариуцсан эмч нар нь айлын хот, хашаа хороонд ариутгал халдваргүйтгэл, үхсэн малын хүүр сэг зэмийг цуглуулан устгаж байна.

Мерси корси олон улсын төслийн газраас Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор бэлчээрт гар худаг засварлуулах 1 төсөл амжилттай хэрэгжихээр болсон.

Аймаг, Сумын Засаг даргын захирамжаар” Үзэмчин хонины ангилалт”- ыг 1-р багийн цөм сүрэг 2200 хонинд хийж гүйцэтгэсэн.

Сумын хэмжээнд 30000 толгой мал төллөсөн, том малын хорогдол 67 толгой мал үүнээс өвчнөөр 11 мал хорогдсон байна.

Усгүй бэлчээрийг усжуулах зорилгоор 3 худгийн захиалгыг ХААГ-т бичгээр хүргүүлсэн. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг 1,4-р багт 13000 га талбайд хийж ажиллахаар төлөвлөөд байна.

Энэ онд 7 га талбайд төмс хүнсний ногоо тариалахаар төлөвлөөд байна.

Нийгмийн, халамж, хамгаалал: Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хүнс тэжээлийн дэмжлэг шаардлагатай өрхийн тоон мэдээллийг гаргаж холбогдох байгууллагад явуулав. Үүнд 26 өрхийн нийт 134 гишүүн үүнээс насанд хүрэгч 63, хүүхэд 71 байлаа.

Мөн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулж 0-18 насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, Бүтэн, хагас өнчин хүүхдүүдийн дэлгэрэнгүй судалгаа, хүүхдүүдийн асран хамгаалагчдын мэдээллийг баг тус бүрээр гаргаж аймгийн ГБХЗХГ-т явуулав. Судалгаанд өрх толгойлсон эцэг 13, бүтэн өнчин 7, хагас өнчин 124 хүүхэд хамрагдлаа.

Байгаль орчин: Сумын засаг даргын 2020 оны 03 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд “Хог хаягдал цэвэрлэх” ажлыг зохион байгуулах 39 бүлэг гарч ажилласны үр дүнд байгууллагууд 2.5 тн, айл өрхийн хашаа гудамжаас 25 тн хог ачуулж хогийн цэгт хаялаа. 40 тн ус, 35 кг суперкилл бодисоор халдваргүйтлийн ажлыг аймгийн мал эмнэлгийн мэргэжилтний тусламжтайгаар зохион байгуулж ажиллалаа.

Санхүү төсөв: ХХОАТатварын хөнгөлөлт эдлэх 60 иргэний 27,892,339.99 төгрөгийг буцаан олгохоор аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

2020 оны 03 дүгээр сарын орон нутгийн орлого өссөн дүнгээр **30294.6** сая төгрөг, гүйцэтгэл 149 хувь байна.

Хөдөө аж ахуй: Мерси корси олон улсын төслийн газраас Бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор бэлчээрийн ургамлын гарц тодорхойлох 4 сая төгрөгний үнэ бүхий иж бүрэн багаж тоног хэрэгслийг хүлээн авсан.

Ногоон алт төслийн газартай хамтран ажиллаж 1 худаг засваруулах ажлын төслийг хүргүүлсэн.

Сэг зэмийн устгал хийж 28 нохой 15 бод, 5 богийн сэгийг хогийн цэгийн ухсан нүхэнд хийж ариутгал хийсэн.

Өвс тэжээлийн нөөцийн үлдэгдэл 5 тн байна.

Сумын хэмжээнд 30000 толгой мал төллөсөн, том малын хорогдол 67 толгой мал үүнээс өвчнөөр 11 мал хорогдсон байна.

1,4-р багийн 13000 га талбайд бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан огтонотой тэмцэх ажил хийгдэнэ.